




ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
ХАРИУЦЛАГАТАЙ АШИГЛАЛТ



The Asia Foundation



Энэхүү гарын авлагыг АНУ-ын Азийн сангаас Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Уул уурхайн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төслийн хүрээнд хэвлүүлэв.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ АШИГЛАЛТ

Талуудад зориулсан гарын авлага



Боловсруулсан: Монголын хоршооллын сургалт
мэдээллийн төв

Г. Гансүх, Коконэт, ТББ-ын Тэргүүн

И.Бямбахүү, МУИС-ийн Хэрэглээ,
шинжлэх ухааны сургуулийн багш

Хянан толилуулсан: П. Болормаа, Азийн Сан

Улаанбаатар хот
2015 он

АГУУЛГА

ОРШИЛ	6
НЭГ. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	9
1.1. Тогтвортой хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд	12
1.2. Тогтвортой хөгжлийн зарчим	16
1.3. Байгаль орчны тулгамдсан асуудлууд	17
1.4. Ногоон эдийн засаг	20
ХОЁР. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ	25
2.1. Усны нөөц	29
2.1.1. Усны нөөцийн зохисгүй ашиглалтын үр дагавар	32
2.1.2. Усны нөөцийн зохистой ашиглалт	34
2.2. Хөрс	38
2.2.1. Хөрсний доройтол, түүний үр дагавар	39
2.3. Биологийн төрөл зүйл	41
2.3.1. Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга замууд	42
2.3.2. Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын талаарх олон улсын шаардлага, зөвлөмж	46
2.4. Бэлчээр	47
2.4.1. Бэлчээрийн зохисгүй ашиглалт ба үр дагавар	48
2.4.2. Бэлчээрийн нөөцийн хариуцлагатай ашиглалт	49
2.5. Эрдэс баялагийн нөөц	51
2.5.1. Эрдэс баялагийн хариуцлагагүй ашиглалтын үр дагавар	51
2.5.2. Эрдэс баялагийн хариуцлагатай ашиглалт	53

ГУРАВ. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦОО	57
3.1. Талуудын оролцоо гэж юу вэ?.....	59
3.1.1. Оролцогч талуудын ашиг сонирхолууд	63
3.1.2. Оролцооны үед тулгардаг бэрхшээлүүд	65
3.2. Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтанд талуудын оролцоог бий болгох	67
3.2.1. Уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах	68
3.2.2. Хамтын ажиллагааны бүтцийг тодорхойлох	70
3.2.3. Талуудын оролцоог хангах зөвлөлийг үүсгэн байгуулах	70
ДӨРӨВ. ОЛОН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	75
4.1. Олон талт зөвлөлийн үйл ажиллагааны үе шатууд	77
4.2. Олон талт хамтын ажиллагааны гэрээ байгуулах	78
4.2.1. Гэрээний төсөл боловсруулах	78
4.2.2. Гэрээний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх	80
4.2.3. Талуудын хооронд хэлэлцээр зохион байгуулах	81
4.2.4. Гэрээ байгуулах	81
4.3. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих	82
4.3.1. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих Олон талт зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх	82
4.4. Гэрээг талууд хамтран дүгнэх	86

ОРШИЛ

Хүрээлэн буй орчин, түүний бүрэлдэхүүн хэсгүүд хүн төрөлхтний эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлдэг гэдгийг олон эрдэмтдийн судалгаанаас харж болно.

Цэвэр агаар, цэнгэг ус, үржил шимт хөрс болон бусад биологийн олон янз байдлууд нь өөр хоорондоо байгалийн өвөрмөц хуулиар нягт холбогдож, экосистемийн тэтгэх чадамжийг бүрдүүлнэ. Үүнийг энгийнээр байгалийн тэнцэл буюу экосистемийн тэнцвэрт байдал гэж хэлдэг. Экосистем гэдэг нь өөр хоорондоо амьдралын болон идэш тэжээлийн хэлхээгээр холбогдсон бүх амьд биес болон тэдгээрийн бодис, энергийн солилцоонд зайлшгүй хэрэгтэй орчин, амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоо юм. Нөгөө талаас экосистемийн тэнцвэртэй байдал нь урт хугацаанд хүн, амьтны тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлж байдаг.

Хүмүүс хэрэглээгээ хангахдаа хүрээлэн буй орчныхоо экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд санаатай болон санамсаргүй хэлбэрээр сөргөөр нөлөөлж, аажмаар өөрсдийнхөө амьдрах орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг устгаж байна. Тухайлбал, ан гөрөө, байгалийн ургамал, түүний үр жимсээр амьдарч байсан тэртээх эрин үед хүмүүс байгалийн баялагийг экосистемийн өөрөө өөрийгөө тэтгэх чадамжийн хүрээнд ашиглаж байсан бөгөөд энэ нь байгаль дэлхий өөрийн жам ёсоор нөхөн сэргэх боломж, бололцоог хангаж байв. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн хүмүүсийн үйл ажиллагаа байгалийн нөөц баялаг хомсдох, экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулах зэрэг байгаль орчинд сөрөг нөлөөгүй байжээ.

Байгалийн арвин нөөц баялагтай улс орнууд хөгжлийнхөө тодорхой үе шатанд улс орныхоо эдийн засаг, өсөн нэмэгдэж буй нийгмийн хэрэгцээг хангахын тулд байгалийн нөөц баялагаа эдийн засгийн эргэлтэнд оруулж ирэв. Орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилт нь хүн төрөлхтний амьдралд асар ихээр нөлөөлж байна. Шинэ машин техник зохион бүтээж, технологи нэвтрүүлэн үйлдвэрлэлээ эрчимжүүлж, газар тариалан, мал аж ахуй эрхлэх, байгалийн нөөц ашиглах, төвлөрсөн хот суурин байгуулах, ашигт малтмал олборлохын тулд ус намгархаг газрыг хатааж, ойг хавтгайруулан огтолж, голын гольдролыг өөрчилж, байгалийн баялагийг эрчимтэй ашиглахын хэрээр экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж, хүрээлэн буй орчны эрсдэл нэмэгдсээр байна. Энэхүү

эрсдлийг бууруулах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, хамгаалах болон нөхөн сэргээхэд тогтвортой хөгжлийн зарчим болон ногоон хөгжлийн загварыг хэрэгжүүлэх шаардлага урган гарч ирлээ.

Ялангуяа аливаа байгалийн нөөцийг ашиглахаас өмнө улс орны эдийн засагт оруулах үр ашиг, нийгэмд үзүүлэх хувь нэмэр, байгаль орчинд нөлөөлөх олон талт байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр талуудын оролцоотой сайтар тооцон үзэж шийдвэрлэх нь тогтвортой хөгжлийн эхний алхам юм. Байгалийн нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулахдаа ашиглагч болон өртөгч талуудын оролцоог жигд хангаж, бүс нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ чухал цаг үед “Тогтвортой хөгжил-Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалт” гарын авлагыг байгаль орчны хамгаалал, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрэл хэрэгцээнд тулгуурлан шинэчлэн боловсруулж олон нийтийн хүртээл болгож байна.

Энэхүү гарын авлага “Тогтвортой хөгжил”, “Байгалийн нөөц ашиглалт”, “Тогтвортой хөгжлийг хангахад талуудын оролцоо”, “Олон талт зөвлөлийн үйл ажиллагаа” гэсэн дөрвөн бүлгээс бүрдэнэ. Мөн Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн зарим заалтууд, болон орон нутагт тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн зарим компаниудын санаачлага жишээг агуулсан болно. Гарын авлагыг боловсруулахдаа аль нэг оролцогч талд зориулсан байдлаар бус харин оролцогч бүх талуудад санаа өгөх, тэдгээрийн цаашдын үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох зорилгоор зөвлөмж болгон гаргав. Үүнийг нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн удирдлага, мэргэжилтэн болон байгалийн нөөц ашиглагч хувийн хэвшлийн байгууллагууд авч ашиглах боломжтой.

Цаашид энэхүү гарын авлагад хууль эрх зүйн орчны өөрчлөлт зэрэг бусад гадаад орчинтой уялдан нэмэлт өөрчлөлт орох, шинэчлэх хэрэгцээ гарах бөгөөд улам боловсронгуй болно гэдэгт эргэлзэхгүй байна. Иймд, эрхэм уншигч та бүхэнд энэ гарын авлагыг цаашид боловсронгуй болгох талаар өөрийн санал бодлыг бидэнд ирүүлнэ гэдэгт найдаж байна. Та санал бодлоо Азийн сангийн bolormaa.purevjav@asiafoundation.org болон Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвийн mctic@mongolia.coop хаягаар илгээнэ үү.



БҮЛЭГ 1

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Улс орнуудын хөгжлийн зорилго нь хүмүүсийг урт удаан хугацаанд эрүүл саруул, бүтээлч амьдралаар амьдрах боломжит орчинг бүрдүүлэхэд оршдог. Мэдлэгийг чөлөөтэй эзэмших, чанартай хүнс, тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ, илүү баталгаатай амьдрах орлого, гэмт хэрэг болон биеийн хүчирхийллээс хамгаалах, чөлөөт цагаа сэтгэл хангалуун өнгөрөөх, улс төр, соёлын эрх чөлөө болон нийгмийн амьдралд оролцох зэрэг нь хүний хөгжлийн үндсэн зорилго юм. Нийгэм бол хүний чадвар чадавхийг хөгжүүлж, тэднийг аливаа боломжид эрх тэгш оролцох нөхцлөөр хангах учиртай.

Шигтгээ: **“Хөгжил** гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхитэй, чөлөөт оролцоонд үндэслэн нийгэмд бий болж буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм соёлын цогц үйл явц мөн”.

НҮБ-ын “Хөгжих эрхийн тухай тунхаглал”

Байгалиа түшиж зохицон амьдрах Монгол ухаан нь өнөөгийн дэлхий дахины тогтвортой хөгжлийн нэг суурь зарчим нь болж байна. Гро Харлем Брундландын тэргүүлсэн Дэлхийн байгаль орчин, хөгжлийн хорооноос “өнөөгийнхөө хэрэгцээ шаардлагыг хангахдаа хойч үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүй байх хөгжил”-ийг тогтвортой хөгжил гэж тодорхойлжээ.

Тогтвортой хөгжлийн ойлголтоос үүдэн гарч буй хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт нь байгаль орчны талаар танин мэдэх, байгаль орчиндоо халамж анхаарал тавих, байгаль орчны асуудлыг захиран зохицуулж буй байгууллагуудтай хамтрах, тэдгээрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох эрх чөлөөг агуулж байгаа юм. Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй ажиллаж амьдрах наад захын стандарт хэм хэмжээ, хүн шиг амьдрах оршихуйн үндэс юм.

Шигтгээ: Хүмүүс эрхээ бүрэн дүүрэн эдэлж, эрхэмсэг, нэр төртэй, хүн шиг амьдарч тасралтгүй хөгжиж, амьдралын чанараа байнга дээшлүүлж байх эрхтэй.

“Хөгжих эрхийн тухай тунхаглал” 1986 он НҮБ

Хүн төрөлхтөний зэрлэг амьтнаас ялгагдах онцлог нь өөрийн амьдрах орчноо амар амгалан байлгаж, ирээдүйгээ ухамсартайгаар төлөвлөж, байгаа бүхнээ ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх гэсэн чин эрмэлзэл, хүсэл тэмүүлэлтэй байдаг. Иймээс өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөн зохион байгуулахдаа хойч үеийнхэндээ байгалийн нөөц баялаг, байгалийн аливаа сайхан нөхцөл бүрийг зөв зохистой хэмжээгээр эдэлж хэрэглэх нөхцлийг бүрдүүлэхээр зохион байгуулж чадвал тогтвортой хөгжил болно.

Тогтвортой хэмээх үг нь хүний амьдралын чанар, хүн төрөлхтөний эв нэгдэл, шударга зарчим, байгаль орчны хамгааллыг эрхэмлэсэн шинэ үнэлэмжинд тулгуурласан хөгжлийн загварыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, зөвхөн эдийн засгийн хөгжлийг хөөцөлдөх биш, байгаль орчныг хамгаалах, нийгмийн амар тайван байдал, уламжлалт соёл, зан заншилд зохицсон энгийн хэрэглээг дэмжсэн нийгэм, эдийн засгийн тэнцвэрт хөгжлийг хангахыг хэлнэ. Иймд өнөө үеийнхэнд амьдарч буй экосистемээ нөхөн сэргээх замаар экосистемийн доройтлыг бууруулахад хувь нэмрээ оруулж, ирээдүй үеийнхний амьдрах нөхцлийг сайжруулах үүрэг, хариуцлага бий болж байна.

Иймд хүмүүст байгаль орчны болон ёс зүйн мэдлэг, үр чадвар эзэмшүүлэх замаар тогтвортой хөгжлийн боловсрол олгох хэрэгцээ гарч байна. Байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглаж, хамгаалах замаар тогтвортой хөгжилд шилжих үеийн боловсролын шаардлага нь байгаль орчны ба хөгжлийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх боломжтой, тогтвортой нийгэмд шилжих үеийн өөрчлөлтөд зохицох чадвартай уян хатан чанарыг эзэмшсэн байхад чиглэгддэг.

1.1 ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

Тогтвортой хөгжил нь эдийн засгийн өсөлтийг хангах, байгаль орчноо хамгаалах болон нийгмийн хөгжлийн асуудлуудын харилцан уялдаа холбоог анхааран авч үздэг. Эдгээр гурван асуудал нь бие биенээсээ хамааралтай, харилцан шүтэлцээтэй бөгөөд тогтвортой хөгжлийн бүрэлдэхүүн хэсгүүд юм. Яагаад гэвэл, бид агаар амьсгалж, ус ууж, хоол хүнс идэж байгалийн баялагийг хэрэглэж байна. Энэ бүгдийг байгаль дэлхий өгч байгаа учир **байгаль орчинг эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн гол суурь** гэж тодорхойлж болох юм.



Эх үүсвэр: Биологийн олон янз байдал болон экосистемийн үйлчилгээ: олон давхаргаас бүрдсэн харилцаа. Экологи хувьслын чиг хандлага 27(1): 19-26 Mace et al. (2012)-ийн зохиол.


Байгаль орчны асуудал

Байгаль орчны үндсэн тулгуур зүйлүүдэд уур амьсгалын зохицуулалт, байгалийн нөөц болон биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүнсний үйлдвэрлэл болон байгалийн усны хангамжийн асуудлууд багтана. Энэ бүхэн хүмүүс биднийг байгалийн цэвэр ургамал, органик хүнс хоолоор хангах нөхцлийг бүрдүүлдэг. Ийм учраас хөрс, ургамал, ан амьтныг хамгаалах, зөв зохистой ашиглах, төрөл бүрийн химийн бодис, пестицидээс татгалзах, бэлчээрийн мал аж ахуй болон органик тэжээлээр тэжээдэг фермерийн аж ахуйг хөгжүүлэх, байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах талаар байнга бодолцож, үйл ажиллагаандаа ашиглах хэрэгтэй.

Тухайлбал, иргэн бүр, байгууллага болгон байгальд халгүй, ээлтэй техник технологи, сэргээгдэх эрчим хүчийг аль болох өргөн ашиглах явдал юм. Мөн онгон байгаль, тусгай хамгаалалттай газрууд, устаж үгүй болох гэж буй биологийн олон янз байдлыг хамгаалах талаарх бодлого шийдвэр гаргахад иргэд, олон нийт, хэсэг бүлгийн оролцоог жигд хангах хэрэгтэй бөгөөд энэ бүхэнд иргэд өөрсдөө эзэн байх эрхтэй.

Дараахь хоёр загварыг харна уу. Эхний загварын хувьд, байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засгийн ач холбогдлыг ижил тэнцүү түвшинд авч үзсэн байна. Эдийн засаг, нийгэм болон байгаль орчны харилцан уялдаа, нөлөөллийг цогцоор нь авч үзсэн нь бат бөх, тогтвортой хөгжих суурийг бий болгож, эмзэг байдлыг бий болгодоггүй.

Харин хоёр дахь загварын хувьд, эдийн засаг, нийгэм соёлын асуудалд илүү ач холбогдлыг өгч, харин байгаль орчны асуудлыг орхигдуулж байгааг харуулж байна. Энэ нь дэлхийн улс орнуудын одоо мөрдөж байгаа эдийн засгийн хөгжлийн загвар юм. Энэ загвар нь байгаль орчны ач холбогдлыг бууруулж, бүх салбарт эмзэг байдлыг нэмэгдүүлж байгааг харуулж байна.



Үүнийг залруулахын тулд байгаль орчны ач холбогдлыг эдийн засаг, нийгэм соёлын түвшинд авч үзэх хэрэгцээ шаардлага урган гарч байгаа юм. Байгалийнхаа нөөцийг ашиглаж эдийн засгийн өсөлтийг бий болгодог, ингэснээр нийгмийн хөгжлийг хурдасгадаг. Тиймээс, байгалийн нөөцөө зөв тооцоотой ашиглах, хадгалан хамгаалж үлдээх нь цаашдын тогтвортой хөгжих үндсэн суурь болно гэдгийг танилцуулж байгаа юм.

Тогтвортой хөгжлийн үндсэн гурван тулга болсон нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг өөр өөр өнцгөөс ярих нь их байдаг. Эдийн засагчид, хувийн хэвшлийн салбарынхан эдийн засгийн тогтвортой хөгжил талаас, нийгмийн салбарынхан боловсрол, эрүүл мэндийн хүртээмж, чанар, ажлын байр, хүний эрх, нийгмийн тэгш байдлыг тогтвортой хангах талаас, байгаль орчны салбарынхан байгаль хамгаалал талаас нь тус тус ярьдаг. Харин тогтвортой хөгжил нь эдийн засаг, нийгэм, байгаль орчны гурван хүчин зүйлийг нэгтгэн цогц байдлаар авч үзэх хөгжлийн загвар юм.



Эдийн засаг

Эдийн засгийн өсөлтийг бий болгохдоо байгаль орчны доройтол, бохирдлоос сэргийлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, хүн амын амьдралын чанарыг сайжруулж, нийгмийн тэгш байдлыг хангахад оршино. Байгалийн нөөц баялагийг хүн амын аж байдлыг дээшлүүлэх, байгаль хамгаалах үндсийг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн зохистой ашиглаж, экологийн хувьд цэвэр, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай.



Хэрэглээний барааг холоос, өөр улс орноос тээвэрлэхэд их хэмжээний бохирдлыг үүсгэдэг, түүнчлэн бензин шатахуунд мөнгө зарцуулсаар барааны үнэ ч нэмэгддэг. Хэдий тийм боловч Монголын хотын хүн ам өсөж байгаатай холбоотой зарим бараа үйлчилгээг гаднаас импортоор оруулах зайлшгүй хэрэгцээ байна. Нөгөө талаас Монголын эдийн засаг байгалийн нөөц баялаг болох нүүрс, зэс, алт, жонш болон мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай байна. Байгалийн нөөцийн экспортоос хамааралтай эдийн засагтай орны хувьд эдгээр эдийн засгийн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хамгийн бага байлгах, тодорхой хязгаараас нь гаргахгүй, сайн жишээ, дадал болгон хөгжүүлэх нь чухал юмаа. Үүнийг ингэж ойлгох хэрэгтэй. Үүнд: үр дүнтэй байгаль орчин, нийгмийн үнэлгээ, том болон бичил уурхайн хор хөнөөллийг бууруулах, бэлчээрийн даацад тохируулсан мал аж ахуйг байлгах. Бэлчээрийн даацыг байнга хэтрүүлээд байвал улс орныхоо бэлчээрийн чанар, даах чадварыг бууруулж, ингэснээрээ уг нутгийн зэрлэг амьтанд сөргөөр нөлөөлөх юм. Учир нь зэрлэг амьтдын хувьд тэдний амьд байх байгалийн эрүүл чанартай орчноос хамаардаг. Олборлох салбар болон мал аж ахуйгаас хэт хамааралтай байх нь эдийн засгийн эмзэг байдал руу оруулдаг, учир нь түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ байнга хэлбэлздэг, харин мал аж ахуй уур амьсгалын үзэгдлээс нилээн хамаардаг. Тиймээс, амьжиргааны олон талын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нь тогтвортой хөгжлийн нэг стратеги байх хэрэгтэй. Жишээлбэл, Монголын хувьд гайхамшигт байгалийн үзэсгэлэнтэй газруудтай, ховор зэрлэг ан амьтантай улс орон тиймээс олон улсын эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь хөдөөгийн эдийг засгийг төрөлжүүлэх, улмаар монголынхоо онгон сайхан байгалиа хадгалж хамгаалж үлдэхэд хувь нэмэр оруулах юм.

Нийгмийн асуудал

Бүх нийтийг нийгмийн суурь үйлчилгээгээр хангах нь суурь чадавхиудыг бий болгох асуудал бөгөөд бүх нийтэд хүртээмжтэй, адил тэгш байх явдал юм. Хүн бүрийг тэгш сайхан амьдралаар амьдруулахын тулд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, ундны усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн болон аюулгүй байдлыг нь хангах зэрэг нийгмийн суурь үйлчилгээг хувь хүний төлбөрийн чадвараас хамааралгүйгээр эрх тэгш хүртээх учиртай. Цаашилбал, сурах илүү сайн боломжуудыг нээж өгөх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, иргэдийн хүний эрх, үүргийн ойлголтыг нэмэгдүүлэх, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрхийн тэгш байдлыг хангах, ядуурлыг бууруулах, хүн төрөлхтөний хөгжин цэцэглэхийн төлөө гэсэн үг.

1.2

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ

Орон нутгийн тогтвортой хөгжлийг бий болгохдоо:

- Байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хөгжүүлэх;
- Иргэдийн нийгмийн хөгжил буюу эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээ;
- Эдийн засгийн хөгжил буюу амьжиргааны тогтвортой орлого бий болгох, орон нутгийн хэрэгцээгээ өөрсдөө хангах, өртөг зардал багатай, нутгийн онцлогт тохирсон үйлчилгээ, хангамжийг хөгжүүлэх чадварыг бий болгох явдал юм.

Байгалийн нөөц, бэлчээр нутаг тогтмол хүрэлцээтэй байж, байгаль эх дэлхий маань бидэнд хэрэгтэй цэвэр агаар, цэнгэг ус, хоол хүнсийг үеийн үед хангах нөхцлийг бүрдүүлж, орон нутгийн иргэдийн орлогын түвшинд нийцсэн үнэ бүхий бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, байгалийн нөөцийн хэмнэлттэй хэрэглээг бий болгосноор тэр хэмжээгээр амьдралын чанар дээшилж, амьжиргаа тогтвортой болно.

Хүний таван мэдрэхүйд хүртэгдэж буй сав шимд тогтвортой хөгжил төвлөрөх зарчим гэдэг нь хүний байгалийн баялагийг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчинд халгүй ээлтэй технологи бүтээх сэтгэлгээг хөгжүүлэх зарчим юм. Тогтвортой хөгжлийг сав шимд төвлөрүүлснээр хүмүүний амьдрах оршихуйн ухааны хэмжүүрийг зөвхөн эд баялагт бус байгалийн хууль жамын дагуу орших, байгалийг тэргүүлэх байранд тавьснаар түүнийг хүлээн зөвшөөрөх, “хүний оюун санааны тэргүүлэх” байр суурь бүрэлдэх үндэс болно гэж үздэг.

Энэ зорилгоор тогтвортой хөгжлийн дараах дөрвөн зарчмыг дэлхий нийтээрээ мөрдөх шаардлага гарч байна. Үүнд:

1. Нөхөн сэргээгдэхгүй нөөц баялаг болон нефть, нүүрс, хүнд металлын хэрэглээг багасгах
2. Синтетик аргаар буюу химийн аргаар гарган авсан байгальд хортой химийн бүтээгдэхүүний хэрэглээг багасгах
3. Байгалийн нөөц, хөрс, ургамал, ан амьтан, газар, усыг хамгаалах менежментийг сайжруулж, нөөцийг зүй бусаар ашиглах, доройтуулахыг бууруулах, зогсоох;
4. Хүмүүсийн хэрэгцээгээ хангах эрхийг хязгаарлахгүйгээр байгалийн нөөцийг зөв зохистой хямгатай ашиглах боломжуудыг бүрдүүлэх

Эдгээр нь эх дэлхийгээ хамгаалах, зөв зохистой ашиглах зааварчилгаа бөгөөд тус зааварчилгааг биелүүлж чадсан тохиолдолд байгалийн нөөцөө хаягдалгүйгээр ашиглаж, газар нутгаа бага бохирдуулж, эх нутгийхаа сайн сайхны төлөө илүү ихийг хийж чадна гэсэн үг. Харин амьдралд хэрэгжүүлж чадахгүй бол байгаль орчин бохирдож, байгалийн нөөц хомсдож, тэнцвэрт байдал алдагдана. Ингэснээр дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, тухайлбал цөлжилт зэрэг сөрөг үр дагаврууд бий болж байна.

Шигтгээ: Монгол улсын Засгийн газар 1998 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 82 тоот тогтоолоор “Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрт байгаль орчны доройтол, таагүй өөрчлөлтийн гол хандлага түүний дотор цөлжилт, ой, ус бэлчээрийн нөөцийн хомсдолтой тэмцэх, улс орныхоо хөгжлийг дэлхийн уур амьсгалын ерөнхий өөрчлөлтийн хандлагад дасан зохицох чадвартай болгохоор заажээ.

1.3 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Сүүлийн жилүүдэд ган, зуд гэх мэт байгаль цаг агаарын хүндрэл бэрхшээл болон үер усны гамшгийн тохиолдох давтамж ихсэж хүн төрөлхтөнд аюул учруулах боллоо. Энэ нь хүний өөрсдийн хариуцлагагүй, буруу үйл ажиллагаа, байгалийн нөөцийн хэт ашиглалт зэргээс ихээхэн хамаарахаас гадна, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс үүдэлтэй юм.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ-ДЭЛХИЙН ДУЛААРАЛ



Өнөөдөр хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа хүнд асуудал бол дэлхийн дулаарал. Дэлхийн эдийн засгийн хямрал, аливаа нэг дайн дажинг хүн төрөлхтөн ямар нэг хэлбэрээр даван түүлж чадна. Харин олон сая жилийн туршид бүрэлдэн бий болсон байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдвал дахин эргүүлэн авах боломжгүй. Иймээс уур амьсгалын талаар хүн бүр ойлголттой болох хэрэгтэй.

Тухайн газар нутагт ажиглагдаж байгаа агаарын хэм, салхи, чийгшил, манан, бороо, цас гэх мэт агаарын шинж байдлыг цаг агаар гэж нэрлэдэг ба харин тухайн газар оронд олон жилээр хэвшин тогтсон цаг агаарын олон жилийн дундаж нөхцлийг уур амьсгал гэнэ.

Уур амьсгал нь тухайн газар нутгийн газар зүйн байршил, тухайлбал далай тэнгисээс алслагдсан байдал, өндөршил, ой, ургамлын бүрхэвчийн байдал зэргээс хамаардаг. Мөн:

- Нарны идэвхжил ба нарны цацрагийн эрчим;
- Дэлхийн ногоон бүрхэвч буюу ой, ургамлын бүрхэвчийн хэмжээ;
- Агаарын найрлаганд зохистой хэмжээгээр байх ёстой нүүрсхүчлийн хий (CO_2), намгийн хий (CH_4), азотын дутуу исэл (N_2O), озон (O_3) зэрэг нэгдлүүдийн хэмжээнээс хамааран өөрчлөгддөг байна.

Учир нь эдгээр хийнүүдийн агаарын найрлаганд эзлэх хувь харьцангуй бага байдаг бөгөөд дэлхийн агаарын хэмийг хэвийн хэмжээнд байлгахад чухал ач холбогдолтой. Хэрэв эдгээр хийнүүд байгаагүйсэн бол дэлхийн гадарга дээрх агаарын дундаж хэм одоогийнхоос -33.2°C хэмээр хүйтэн байх байжээ. Дэлхийн агаар мандал нь дэлхийн гадаргын дулааны горимд чухал үүрэгтэй. Харамсалтай нь дэлхийн хүн амын өсөлт, аж үйлдвэрлэлийн эрчимжилт, байгалийн нөөцийн хэт ашиглалтаас болж агаар мандалд байгаа нүүрс хүчлийн хий, намгийн хий, азотын дутуу исэл, озон зэрэг нэгдлүүдийн хэмжээ өөрчлөгдөж эхэлжээ. Үүнийг “хүлэмжийн хий”-н нөлөө хэмээн нэрлэдэг.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хорооны 2007 онд нийтлэн гаргасан үнэлгээний 4 дэх тайланд “ХХ зууны дунд үеэс хойш дэлхийн дундаж температур өссөн гол шалтгаан бол хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн агууламжийн ихсэлтээс шалтгаалсан нь маш өндөр магадлалтай байна” гэж цохон тэмдэглэсэн байдаг. Дэлхийн дулааралд нөлөөлж буй гол хүлэмжийн хийнүүд нь нүүрсхүчлийн хий, метан буюу намгийн хий, азотын дутуу исэл, фторт-нүүрс-үстөрөгчийн хийнүүд юм. Нийт хүлэмжийн хийн:

- Нүүрсхүчлийн хий 76.7 хувийг;
- Намгийн хий буюу метан 14.35 хувийг;
- Азотын дутуу исэл 7.9 хувийг,
- Фторт-нүүрс-үстөрөгчийн хийнүүд 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Нүүрс хүчлийн ялгаралтыг нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

- Ой модыг хэт ихээр ашигласнаар;
- Бэлчээр ба ургамлан нөмрөгийг талхлах, доройтуулах;
- Үйлдвэрлэл, халаалт болон авто машинаас их хэмжээгээр ялгарч буй нүүрс хүчлийн хий;
- Малын тоо толгой хэт ихээр өсөх.

Агаар дахь хүлэмжийн хий хэвийн хэмжээнээс ихсэж, нэмэгдсэнээс уур амьсгал дулаарч үүнээс үүдэлтэйгээр хуурайшилт, цөлжилт явагдаж, байгаль, нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахын тулд нүүрс хүчлийн хийн ялгаралтыг бууруулах зорилт дэвшүүлдэг.

Шигтгээ: Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага

Судлаачид Монгол орны агаарын жилийн дундаж температур 1940 оноос хойш 2.1°C-аар дулаарсан болохыг тогтоожээ. XXI зууны уур амьсгалын ерөнхий төрхийг үнэлэхийн тулд судлаачид дэлхийн хүн амын өсөлт, технологи, нийгэм эдийн засгийн хөгжлийн хандлагын янз бүрийн нөхцөлд агаарт хаягдах хүлэмжийн хийн ялгаралтын хувилбаруудын бүлэглэлийг тодорхойлжээ. Өндөр хөгжилтэй орнуудын боловсруулсан загваруудын тооцооны үр дүнг бүс нутгийн хэмжээнд буулган, Монгол орны уур амьсгалын ирээдүйн хандлагыг тодорхойлбол дулааралт өвлийг бодвол зуны улиралд харьцангуй эрчимтэй ажиглагдах болж. Тухайлбал 2011-2030 оны үед 1.1-1.4°C, 2046-2065 оны үед 2.7-3.6°C, 2080-2099 оны үед 3.7-6.3°C тус тус нэмэгдэх төлөвтэй байна. Харин өвлийн улиралд 2011-2030 оны үед 0.2-0.7°C, 2046-2065 оны үед 1.6-2.5°C, 2080-2099 оны үед 3.0-3.8°C нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр өвлийн хүйтэн зөөлөрч, цас их орох, харин зуны халуун эрчимжих, хур тунадас бага хэмжээгээр нэмэгдэх хэдий ч хуурайших дүр зураг бууж байна.

Эх сурвалж: <http://www.climatechange.gov.mn/>

ЦӨЛЖИЛТ

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр ялангуяа дэлхийн гадаргын усны нөөц ядмаг хуурай бүс нутгуудын газар элэгдэл, эвдрэл доройтолд орж, үржил шимээ алдан, аажмаар цөлжих үйл явц улам бүр хүрээгээ тэлэв. Эдгээр улс орнуудад хүн амын хүнс тэжээл хомсдон, өлсгөлөн ядуурал эрчимжиж байна.



НҮБ-ын мэдээнээс үзвэл манай дэлхийн хуурай газрын гуравны нэг нь ямар нэг хэмжээгээр доройтолд орж, жил бүр 6 сая га газар цөл болон хувирч, цөлжилтийн сөрөг нөлөөнд 250 сая гаруй хүмүүс нэрвэгдэж байгаа ажээ.

Монгол орон газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, гадаргын хэв шинжийн хувьд цөлжилтийн аюулд өртөх эмзэг, хуурай бүс нутагт хамрагдах бөгөөд нутаг дэвсгэрийн 42.5 хувь нь говь цөлийн бүсэд, 84.7 хувь нь далайн түвшнээс 1000 метрээс дээш өргөгдөж, 40.6 хувь нь цайвар хүрэн, цөлийн бор саарал элсэн хөрс зонхилох экосистемээс бүрддэг. Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтаас үлбаалан цөлжилт хүрээгээ тэлсээр нүүр, ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц эрс муудах, хөрс, ус давсжин, үржил шимээ алдах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх болжээ. Нутгийн 76 хувьд нь цөлжилт сул, 20 хувьд дунд зэрэг, 3 хувьд нь хүчтэй нэг хувьд нь маш хүчтэй илэрсэн талаар Геоэкологийн хүрээлэнгийн судалгааны тайланд дурджээ.

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 72 хувь нь их бага хэмжээгээр цөлжилтөнд өртсөн бөгөөд үүнээс 23 хувь нь сул, 26 хувь нь дунд, 18 хувь нь хүчтэй, 5 хувь нь нэн хүчтэй зэрэглэлд хамрагджээ. Өөрөөр хэлбэл, манай орны нийт нутаг дэвсгэрийн 49 гаруй хувь нь дундаас дээш зэрэглэлийн цөлжилт, газрын доройтолд өртсөн байна.

Хүний үйлдлээр цөлжих үйл явц нь бэлчээрийн талхагдал, үүл уурхайн үйл ажиллагаа, ойн хомсдол, гадаргын усны хомсдол, хог хаягдал ихсэх, хүн амын сэтгэл зүйн “цөлжилт” зэрэг болно.

1.4 НОГООН ЭДИЙН ЗАСАГ

Ази тив нь дэлхийн бусад тивтэй харьцуулахад эдийн засаг, хүн ам хурдацтай өсөн нэмэгдэж буй бүс нутаг юм. Энэхүү өсөн нэмэгдэж байгаа эдийн засаг болон аж үйлдвэржилт эрчимтэй өсөхийн хэрээр хоол, хүнс, эрчим хүчний хэрэглээг хангахын тулд нөхөн сэргээгдэх болон нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөцийн ашиглалт асар ихээр нэмэгдэв. Байгалийн нөөцийн хэт их ашиглалт нь нөөцийн хомсдол болон биологийн төрөл зүйл устгах зэргээр байгаль орчны болоод улс орны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж эхэлсэн болохыг улс орнууд хүлээн зөвшөөрч эхэлжээ. Сүүлийн жилүүдэд байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан хөгжлийн загварууд, тухайлбал “ногоон эдийн засаг”, “ногоон өсөлт”, “ногоон гүүр” болон “ногоон хөгжил” зэрэг ойлголтууд түгэн гарч ирлээ.



2012 оны 6 дугаар сард Бразил улсын Рио де Жанейро хотноо Тогтвортой хөгжлийн талаар НҮБ-ын “Рио+20” бага хурал зохион байгуулагдсан. Хурлаар дэлхийн хүн төрөлхтний ирээдүйн 20 жилийн хөгжлийг тодорхойлох ногоон эдийн засгийн олон улсын бодлогын баримт бичгийг хэлэлцэж, тогтвортой хөгжлийн тунхаглалыг батлав. Тогтвортой хөгжлийн ирээдүйг баталгаажуулахын тулд эдийн засаг, нийгэм болон байгаль орчны харилцан уялдаа, нөлөөллийг цогцоор нь авч үзэх шаардлагатай болохыг чухалчлан авч үзжээ. Эндээс ногоон эдийн засгийг тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах чухал арга хэрэгслийн нэг болохыг зөвлөсөн.

Тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулах чухал арга хэрэгслийн нэг ногоон эдийн засгийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрт “хүрээлэн буй орчны эрсдэл болон экологийн хомсдолыг эрс бууруулахын сацуу хүн төрөлхтний сайн сайхан, нийгмийн эрх, тэгш, шударга байдлыг хангах” гэж тодорхойлжээ. Энгийн үгээр тайлбарлавал ногоон эдийн засаг гэдэг нь нүүрстөрөгчийн бага ялгаралт, байгалийн нөөц баялгийн үр ашигтай хэрэглээ болон бусад нийгмийн асуудлуудыг багтаасан цогц ойлголт юм. Тэгэхлээр тухайн улс орны эдийн засгийг ногоон эдийн засагт шилжих боломжийг хэрхэн ямар аргачлалаар үнэлэх вэ гэдэг асуудал гарч ирж байна. Улс орнуудын эдийн засгийн салбар бүр нь тухайн салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт, үр ашиг, хэрэглэж буй байгалийн нөөцийн хэмжээ, ажиллагсад болон тухайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ зэргээрээ ялгаатай байдаг. Үүнтэй холбоотойгоор улс орны эдийн засагт тэдгээрийн үзүүлэх хувь нэмэр өөр өөр.

НҮБ-аас хүний хөгжлийн индекс болон экологийн үл мөрийг харьцуулах аргаар

дэлхийн улс орнуудыг ногоон эдийн засагт шилжих нөхцөл, боломжийн талаар доорх дүгнэлтэнд хүрчээ. Үүнд:

1. *Хүрэн эдийн засаг боловч ногоон болгох боломжтой хэлбэр.* Өнөөгийн байдлаар экологийн үл мөр болон хүний хөгжлийн индекс бага улс орны хувьд цаашид байгалийн нөөцийн ашиглалтандаа зөв менежмент хийвэл ногоон эдийн засагт шилжих боломж байна гэж үзнэ.
2. *Хүрэн эдийн засаг, байгалийн нөөцийн хомсдолтой хэлбэр.* Хүний хөгжлийн индекс нь их түүнийг дагаад экологийн үл мөр нь мөн их, улс орнуудын хувьд байгалийн нөөц хэт их ашиглагдсан болохоор тэдгээрийг нөхөн сэргээх, экосистемийн тэтгэх чадамжийг нэмэгдүүлэхэд ихээхэн хөрөнгө мөнгө шаардлагатай бөгөөд энэ хэмжээгээр ногоон эдийн засагтай орон болоход хугацаа их шаардана гэж үзнэ.
3. *Ногоон эдийн засаг.* Хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлэхэд байгалийн нөөц баялагийг хэмнэлттэй ашиглах, хүрээлэн буй орчны эрсдлийг бууруулсан, хүлэмжийн хийн ялгарал багатай замаар экологийн үл мөрийг экосистемийн тэтгэх чадамжаас хэтрүүлэхгүй хөгжиж байгаа улс орнуудыг ногоон эдийн засагтай гэж үзнэ.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд нэг хүнд ноогдох экологийн үл мөрийг ихэсгэхгүй байхын зэрэгцээ хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлэх нь улс орнуудын хувьд ногоон эдийн засагт шилжих боломжтой эсэхийг тодорхойлох үндсэн шалгуур болох юм. Мөн энэ шалгуурыг ашиглан тухайн орон анхан шатны байдлаар хүрэн эсвэл ногоон эдийн засгийн аль хэлбэрт байгааг тогтоохоос гадна тухайн улс орон цаашид ногоон эдийн засагт шилжихэд анхаарах асуудлуудыг тодорхойлоход дөхөм болно.

Нөгөө талаас нь авч үзвэл эдийн засгийн өсөлтийг хангахад байгалийн нөөц баялагийг эрчимтэй ашиглах дүр зураг нь тухайн улс орны хөгжлийг илэрхийлж байна. Хэдий тийм ч байгаль орчны доройтлын асуудал нь буурай болон хөгжиж буй улс орнуудыг хөгжингүй улс орнуудтай харьцуулбал илүү хүнд (UNCTAD 2010a). Иймд байгаль орчинд ээлтэй хөгжлийн загвар руу шилжих нь нэн чухал ач холбогдолтой юм. Мөн байгаль орчинд ээлтэй эдийн засгийн байнгын өсөлтийг хангахын зэрэгцээ хүний сайн сайхан байдлыг хангах боломжийг олгох ногоон хөгжлийн загварыг амжилттай хэрэгжүүлж байгаа олон улс орон бий. Өмнөд



Солонгос улс ногоон өсөлтийг дэмжих санаачлагыг тэргүүлэх орнуудын тоонд багтдаг. Тус улс дэвшилттэй технологиудыг нутагшуулах замаар технологийн дэвшилтэд өөрчлөлт хийж, эдийн засгийн өсөлт, инновацийг сайн хөгжүүлж чадсан, мөн ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулж, эдийн засгаа ногоон маягаар хөгжүүлэх урт хугацааны төлөвлөлт хийж хэрэгжүүлээд тодорхой үр дүнд хүрч байна.

Харин Герман улс ногоон эдийн засагт шилжих зорилгоор дараах өөрчлөлт, санаачлагуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал ногоон татварын систем, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй хөнгөлөлт, урамшууллыг хүчингүй болгох, ногоон эдийн засгийг дэмжсэн үнийн бодлого, хүрээлэн буй орчны бохирдол, хаягдлыг зохицуулах эрх зүйн орчин, эдийн засгийн өсөлтийг хангахын сацуу хүрээлэн буй орчинд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинд нөлөөлөл багатай бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, байгаль орчны салбарт үзүүлдэг тусламж, хандивыг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаа юм.

Улс орнуудын ногоон эдийн засаг болон ногоон хөгжилд шилжихээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь хэдийгээр тухайн улсын урт хугацааны хөгжлийн бодлого, эдийн засгаас шалтгаалан өөр өөр боловч ижил төстэй түгээмэл зүй тогтолтойг судлаачид тогтоожээ. Түгээмэл байгаа нь:

- Ногоон өсөлт, ногоон эдийн засаг, ногоон хөгжлийг дэмжсэн бодлого, хөтөлбөрүүд;
- Хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах татвар, санхүү, зах зээлийн зохицуулалт;
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;
- Эрчим хүч, материал, түүхий эдийн хэрэглээг багасгахад чиглэгдсэн арга хэмжээ,
- Технологийн шинэчлэл;
- Ногоон хотжилт, ногоон дэд бүтэц;
- Ногоон амьдралын хэв маягийг нийгмийн амьдралд нэвтрүүлэх зэрэг юм.

Шигтгээ: Монгол улс тогтвортой хөгжлийн талаар

Монгол улсын хувьд тогтвортой хөгжилд хүрэх, ногоон эдийн засагт шилжихийн тулд тодорхой зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж эхэлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох”, ногоон хөгжлийн үндсийг бүрдүүлэн, ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж, загваруудыг бий болгохоор заасан. Монгол Улсын Их Хурлын 2014.06.13 өдрийн хуралдаанаар “Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай” тогтоолыг хэлэлцэн баталжээ. Ногоон хөгжлийн үзэл баримтлалд а) Уур амьсгалд зохицсон хөгжил, б) Ногоон эдийн засаг ба санхүүжилт, в) Ажил, орлоготой ард иргэд бүхий тэгш нийгэм, г) Соёл ба өв, д) Тогтвортой хөгжилд хүрэх засаглал гэсэн таван үндсэн чиглэлээр найман зорилго бүхий 39 зорилт тусгажээ.

Ногоон хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрт 2020 он хүртэл түүнийг хэрэгжүүлэх бодлогын болон үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон нүүрстөрөгч багатай хөгжлийн эхлэлийг тавих;
- Эрчим хүчний хангамжинд сэргээгдэх эх үүсвэрийн эзлэх хувийг нэмэгдүүлэх;
- Дотоодын түүхий эд, нөөцийг боловсруулах болон ашигт малтмалын бус эдийн засгийн салбарыг төрөлжүүлэн хөгжүүлэх;
- Усан хангамж, ариун цэврийн болон байгальд халгүй, нөөцийн үр ашигтай эрчим хүч, зам тээвэр, барилга зэрэг дэд бүтцийн хангамжид оруулах ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Байгаль орчинд халтай бараа, үйлчилгээний үйлдвэрлэл, хэрэглээг бууруулах зорилт, үйл ажиллагаа, зах зээлийн зохицуулалтыг тусгасан байна.

Түүнчлэн иргэд боловсрол, үр чадвараа дээшлүүлэн амьдралын чанараа сайжруулах ижил тэгш боломжийг бүрдүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх салбар дундын уялдаа, зохицуулалтыг сайжруулах засаглалыг бэхжүүлэх, түүх соёлыг хадгалан хамгаалах, байгалийн эмзэг тогтоц, хөдөө аж ахуйн онцгой ач холбогдолтой газар нутгийн хамгаалалт бүхий экологийн цэвэр үйлдвэрлэлийг дэмжсэн ногоон хөгжил бүхий газар, нутгийн хөгжлийг бий болгох бодлогыг мөн хамруулжээ.

Энэхүү ногоон хөгжлийн бодлогыг Монгол улсын хөгжлийн тулгуур бодлогын нэг болгосноор нүүрс төрөгчийн ялгаралт болон хүрээлэн буй орчны эрсдэлийг бууруулах, байгалийн нөөц баялгийг үр ашигтай ашиглах, экосистемийн үйлчилгээ болон биологийн олон янз байдлын хомсдолоос урьдчилан сэргийлэхэд ихээхэн дэвшил гарах нь дамжиггүй.



БҮЛЭГ 2

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАЛТ

Монгол улсын хувьд хөдөөгийн болоод суурин иргэдийн ахуй амьдралын онцлог, нийгмийн олон талт үйл ажиллагаанд оролцох байдал, эдийн засагт үзүүлэх хувь нэмэр, байгалийн нөөц, баялагийг ашиглах байдлаас хамаарч тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй.

Нийгмийн хөгжил дэвшил-эдийн засгийн өсөлтийн хурдыг хангах бүтээн байгуулалт, аж үйлдвэржилтийн улмаас байгалийн нөөц, баялагийн ашиглалт сүүлийн жилүүдэд асар ихээр нэмэгдэж байна. Бүтээн байгуулалтын олон төслийн үйл ажиллагаа, уур амьсгалын өөрчлөлтийн хавсарсан нөлөөлөл нь Монгол орны байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд, тухайлбал уламжлалт бэлчээрийн мал аж ахуй, цөлжилт, агаарын бохирдол, усны нөөц болон нутгийн иргэдийн амьдрах орчинд олон таагүй асуудлуудыг дагуулах болсныг эрдэмтэд, судлаачид тогтоосон.

Шигтгээ: Монгол орны байгаль экологийн онцлог

Монгол орны байгаль экологийн өвөрмөц онцлогт давуу болон сүл тал бий. Монгол орон байгаль цаг уурын давтагдашгүй өвөрмөц онцлогтой бөгөөд энэ онцлог нь юуны өмнө экологийн ихээхэн эмзэг шинж чанар, нөхөн төлжих, сэргээгдэх чадвараар харьцангуй сул. Тэрчлэн байгаль орчин эдүгээг хүртэл харьцангуй цэвэр унаган төрхөө хадгалж чадсан байдалтай боловч сүүлийн 60–иад жилд нийгэм эдийн засгийн хөгжлийн шаардлагаар зам тээвэр, харилцаа холбоо, уул уурхай эрчим хүч, газар тариалан зэрэг салбарыг эрчимтэй хөгжүүлж, улмаар олон арван том хот суурин байгуулснаар байгаль орчин эдийн засгийн тогтвортой харилцаанд гүнзгий өөрчлөлт гарсан.

МУ-н шинжлэх ухааны академи 2010 он. “Монголын байгаль орчны нэвтэрхий толь” 173-р тал

Эдгээр олон хүчин зүйлүүд, нэн ялангуяа уул уурхайн хариуцлагагүй олборлолт, ашиглалт нь бэлчээр нутгаа түшин амьдарч буй малчид, орон нутгийн иргэдийн амьдрах орчин, экологийг улам доройтуулж байна. Гэсэн ч сүүлийн жилүүдэд дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам, гарцуудын талаар эрдэмтэн, судлаачид, иргэд санал дэвшүүлж, засгийн газрын зүгээс тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа нь сайшаалтай. Цаашид тодорхой, бодит үр дүнд хүрэхийн тулд иргэн бүр байгалийн нөөц, түүний ашиглалтын талаар мэдлэг, ойлголттой байх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Байгалийн нөөц гэсэн ойлголт нь хүний гараар бүтээгдээгүй, байгальд оршин байдаг, хүн ба амьд амьдралын оршин тогтнохуйн үндэс болсон ус, хөрс, агаар, ой, эрдэс, бусад биологийн нөөцийг хэлдэг. Монгол улсын үндсэн хуулийн 6.1-д *Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад нөөц гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтанд байна* гэж заажээ.

Учир нь байгалийн нөөцийг ашиглах нь хүний амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах зэрэг хүнд байгалиас заяасан үндсэн эрхүүдтэй¹ шууд холбоотой байдаг.

Байгалийн нөөц гэсэн ойлголтыг олон янзаар ангилан авч үздэг. Тухайлбал ашиглагдах байдлаар нь шавхагдах нөөц ба үл шавхагдах нөөц гэж 2 ангилна. Шавхагдах нөөцийг дотор нь сэргээгдэхгүй, харьцангуй сэргээгдэх, сэргээгдэх гэж ангилдаг.

Шавхагдах нөөц	Тодорхойлолт
Сэргээгдэхгүй	Дахин бий болохгүй буюу эсвэл бий болохдоо хүн ашиглах хурдаас удаан бий болдог газрын хэвлийн нөөц буюу эрдэс баялаг юм.
Харьцангуй сэргээгдэх	Хуурай газрын дээд сэвсгэр үе буюу таримлын ургац өгөх чадвартай хөрс, ойн нөөц хамаарна. Хөрс хамгийн үнэтэй нөөц бөгөөд цаг уур, амьд организмын оролцоотойгоор маш удаан сэргээгдэнэ.
Сэргээгдэх	Амьтан ургамлын аймаг, нуур тэнгисийн усанд тунах давс зэрэг зарим эрдсүүд хамаарна. Ийм нөөцийн сэргээгдэх хугацаа нь харилцан адилгүй байна.

Дээр дурдсан шавхагдах нөөц, баялагуудын тодорхойлолтоос үзэхэд харьцангуй сэргээгдэх нөөц болох хөрс, ойн нөөц зэрэг нь байгаль цаг уур, амьд организмын оролцоотойгоор маш удаан хугацаанд сэргээгддэг онцлогтой ажээ. Харин нөхөн сэргээгдэх хугацаа нь харилцан адилгүй байна. Харьцангуй сэргээгдэх болон сэргээгдэх нөөцийн ашиглалтын хурдац түүнийг дахин бий болох хурдацтай тохирч байх ёстой.

Байгалийн нөөцийн өөр нэг чухал ангилал бол байгаль орчны чухал бүрэлдэхүүн хэсэг талаас нь газрын, усны, ойн, эрдэст, эрчим хүчний гэж ангилдаг байна. Манай орон ус, хөрс, ой болон бусад биологийн нөөцөөр хязгаарлагдмал орон.

Гадаргын байнгын урсацаар ядраг говийн бүсэд нэг хүнд ногдох усны нөөц дэлхийн дунджаас 10 дахин бага² байдаг бөгөөд Монголын өмнөд бүс дэх бүх хөрсний ус нь дахин сэргээгддэггүй нэг удаагийн нөөц тул түүнийг ашиглахад тухайн газрын

¹ Хүний үндсэн эрхэд (жам ёсны, үндсэн, тулгуур, салшгүй гэх мэтээр янз бүрээр бичдэг) хүн бүрт төрсөн цагаас нь эхлэн тэгш хамаарах, хэзээч хагацаж үл болох эрхүүдийг ойлгоно. Үндсэн эрхийг эдэлж хэрэгжүүлэх боломж тухайн улсын түүхэн хөгжил, өвөрмөц онцлог, ард түмний зан заншилтай холбоотой. Үндсэн эрхийн талаар хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Эрх чөлөөтэй, тэгш байх нь хүний салшгүй эрх бөгөөд түүнээс хагацаж болохгүй. Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй гэж заасан нь бусад бүх эрхүүдийг эдлэх гол тулгуур болдог.

² Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний III илтгэлийн хураангуй. Улаанбаатар хот 2009 он. 15-р тал

дахин давтагдашгүй экосистем, түүний ландшафтын төвшинд өөрчлөлт хамгийн багатай байх нөхцлийг зохицуулах цогц бодлого шаарддаг.

Монгол улс нь төв Азийн өндөрлөг газарт орших бөгөөд энэхүү физик, газарзүйн онцлог нь эх газрын эрс тэс уур амьсгалыг бүрдүүлж, улмаар улирлын ялгаа ихтэй учир экосистемийн хувьд маш эмзэг бүс нутаг. Энэ зүй тогтлоос хамаарч, Монгол орны хувьд хөрсний төрөл, түүний ялзмаг нь маш эмзэг байдаг учир бусад бүс нутгаас 3 дахин илүү хурдтай хөрсний элэгдэл үүсч, цөлжилт явагддаг онцлогтой. Манай орны ойн сангийн дийлэнх хувийг байгалийн жамаараа нөхөн сэргээх чадвар хязгаарлагдмал навчит, шилмүүст ой эзэлдэг³. 2011 эхний байдлаар 18,6 сая га талбай буюу нийт нутаг дэвсгэрийн 11,8 хувийг эзэлж байна⁴. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан жишгээр ойн нөөцөөр хомс орны тоонд багтдаг.

Сүүлийн 30 жилийн турш тариалангийн талбайн 46.5 хувь нь гүн болон дунд хэмжээний эвдрэлд орж, ойн талбай 1.4 сая га-гаар багасч 6.9 сая га бэлчээр талхлагдсан. Бэлчээрийн даац бараг 5 дахин буурч, ургамлын нэр төрөл бараг 4 дахин цөөрчээ.

2.1. УСНЫ НӨӨЦ

Усыг тойрсон асуудлууд нь өнөөгийн манай гаригт нүүрлээд байгаа хамгийн ноцтой асуудлуудын нэг гэдгийг дэлхий даяараа хүлээн зөвшөөрөөд байна. 2009 оны 15 орны гучин хоёр мянган хүнээс авсан судалгааны дүнгээр хүмүүсийн 90 орчим хувь усны бохирдол, цэвэр усны гачигдлыг хамгийн ноцтой асуудал гэж үзжээ. Хүмүүс дэлхийн дулаарал, байгалийн нөөцийн хомсдол зэрэг асуудлуудаас илүүтэйгээр усны хэрэглээ, усны бохирдлыг тойрсон асуудалд санаа зовж байна.



БАРИМТ 1. Усны асуудалд хандаж буй чиг хандлага (график 1)



Эх сурвалж: Усны асуудал судалгаа, Глоб скен судалгаа, 2009

³ Монголын байгаль орчны нэвтэрхий толь.

⁴ Ногоон ертөнц байгаль орчин ТББ болон НҮБ-н Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын ойн газрын хамтарсан цахим хуудас <http://www.gwe.mn/oin-tuhai/54-oin-san.html>

Усны бодлого гэдэг нь ихэвчлэн усны менежмент буюу түүнд холбоо хамааралтай хууль, дүрэм журам гэсэн ойлголт иргэдийн дунд тогтсон байдаг. Товчоор хэлбэл усны менежменттэй холбоотой дүрэм журам, зарчим, бодлогыг багтаан ойлгож болно. Жишээ нь, дэд бүтцийн хөгжил дэвшил, усны талаарх холбогдох хууль тогтоомж, хүрээлэн буй орчны хамгаалал, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой хууль эрх зүй зэргийг энэ хүрээнд ойлгож болно. Усны аюулгүй байдлыг хангахад тухайн улсын Засгийн газраас голлох үүргийг гүйцэтгэх шаардлагатай бол бодлогын хэрэгжилтэд иргэний нийгэм, хувийн компани, хувь хүн, албан байгууллагуудын оролцоо нэн чухал юм. Усны хангамж, дэд бүтцийн хөгжил дэвшил, усны түгээлт, усны нөөцийн хамгаалал, усны чанарын менежмент бохирдлын хяналт, усны үнэлгээ, эдийн засгийн үзүүлэлт, усны менежментийн системийн үйл ажиллагаа, байдал, ариутгах үйлчилгээ, ус ашиглалт, устай холбоотой бодлого боловсруулах үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо, хүрээлэн буй байгаль орчинтой холбоотой дүрэм, журам, төлөвлөлт, биологийн төрөл зүйлийн хамгаалалт болон дархан цаазат газруудын менежмент зэрэг зүйлс нь аливаа бизнесийн үйл ажиллагааны үндсэн гол зүйлс тул усны бодлогыг тодорхойлоход ихээхэн нөлөөтэй болно.

Усны тогтвортой байдлын дөрвөн гол хүчин зүйлсийг тодорхойлох нь

Тогтвортой байдлын голлох хүчин зүйлсийг үр дүнтэй хэрэгжүүлснээр усны тогтвортой менежмент бий болно гэсэн үг юм. Эдгээрт:

1. **Нийгмийн тогтвортой байдал:** Бүх хүн өдөр тутмын аж амьдрал болон эрүүл ахуйн шаардлагын үүднээс хангалттай хэмжээний усыг өдөр бүр хэрэглэх шаардлагатай байдаг тул усны бодлоготой хамааралтай бодлого боловсруулалтанд иргэдийн оролцоо тодорхой хэмжээгээр байх нь зайлшгүй юм.
2. **Хүрээлэн буй байгаль орчны тогтвортой байдал:** Ямар амьтан буюу бодгаль гэдгээс үл хамааран бүх амьд бие ус хэрэглэдэг билээ. Энгийнээр хэлбэл тухайн нийгмийн тогтвортой байдалд тухайн хэсэгт амьдрагч амьд биет, экологийн буюу усны процесс нэн чухал салгаж үзэх боломжгүй хэсэг нь болдог.
3. **Эдийн засгийн тогтвортой байдал:** Усны менежментийг боловсруулахдаа үнэ өртгийн хувьд аль болох хямд төсөр, эдийн засгийн үнэлгээ, санхүүгийн эрсдлийг тооцож, аль болох багасгаж, тэнцвэртэй байдлыг бий болгох нь зүйтэй юм.
4. **Байгууллагын тогтвортой байдал:** Усны нөөц хангалттай сайн байж чадвал тухайн байгууллага тэр хэмжээгээр удаан хугацаанд тогтвортой ажиллах боломжтой юм.

Монгол улсын усны тухай хуульд “Усны нөөц” гэж одоо ашиглаж байгаа цаашид ашиглаж болох гадаргын болон газрын доорхи усыг хэлнэ гэж заажээ. Манай орны байгалийн усны нөөцийн 90 гаруй хувь нь гадаргын ус, зөвхөн 2 хувь нь газрын доорх ус гэж үздэг. Гадаргын усны 82 хувь нь нууранд, 10.4 хувь нь мөстөл, мөсөн голд, 5.6 хувь нь гол мөрөнд агуулагддаг. Ус нь байнгын хөдөлгөөнд байж, зарцуулагдаж, нөхөн сэргээгдэж байдаг. Нөхөн сэргээгдэх хугацаа нь түүний байрлалаас хамаарч хэдэн цагаас хэдэн мянган жил байна.

Жич: Усны нөхөн сэргээлт гэдэг бол харьцангуй ойлголт. Хэдийгээр гүний усны нөхөн сэргээлт 1400 жил гэж байгаа боловч энэ нь хэзээ ч нөхөн сэргээгддэггүй баялаг юм. Тухайлбал манай орны говийн газрын доорхи ус бол хэдэн мянган жилийн туршид бий болсон нөөц. Үүнийг уул уурхай хөгжиж буй энэ хэдхэн жилд ашиглачих юм бол хойч үе маань яах билээ, говьд амьдрал үргэлжилнэ.

Голын ус хамгийн хөдөлгөөнтэй, харьцангуй хурдан буюу 16 хоногт нөхөгддөг байна.

Манай улс усны хэрэглээнийхээ 80 гаруй хувийг газрын доорх усаар хангадаг. Улсын хэмжээнд 2010 онд нийт хэрэглэсэн 553.0 сая м³ усны 80 гаруй хувь буюу 443.0 сая м³ газрын доорх уснаас хангасан гэсэн тооцоо бий. Энэ нь манай улс газар доорх усны нөөцөө үлэмж ихээр хэрэглэдэг болохыг харуулж буй бодит үзүүлэлт юм. Газрын доорх ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, усны горим тэжээлийн систем нь өвөрмөц, нөхөн сэргээх хугацаа нь хэдэн арав, хэдэн зуун жилээр тооцогддог учраас газрын доорхи усыг онцгой хамгаалалтад авч, нөхөн сэлбэгдэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр ашиглах шаардлагатай⁵. Иймд, газрын доорх усны нөөцийг зөв зохистой хэмнэлттэй ашиглахад дэлхийн улс орнуудын сайн туршлагуудыг нэвтрүүлэн хэрэглэх нь чухал. Уул уурхайд усыг дахин ашиглах, хэмнэх технологийг түлхүү нэвтрүүлэх ёстой. Усыг дахин ашиглах тохиолдолд ус бохирдуулсны төлбөрөөс тодорхой хувь хэмжээгээр хөнгөлөх зэргээр зохицуулалт байж болох юм. Дэлхий дахинаараа саарал ус гэж ярих болсон. Манайд дөнгөж л ойлгуулах хэмжээнд байх шиг байна. Саарал усыг яагаад ашиглахгүй байна вэ гэвэл өртөг зардал нь цэвэр усыг ашиглахтай харьцуулахад үнэтэй байгаад л гол учир нь байдаг⁶.

⁵ Монголын байгаль орчны нэвтэрхий толь 255-р хуудас

⁶ www.uuluurhai.mn

Тухайлбал, дэлхийн хуурай болон хагас хуурай бүс дэх улс орнууд газар доорх усны нөөцийнхөө 10 хувиас хэтрүүлэхгүй ашиглахаар төлөвлөдөг. Ийм бүс дэх усны хэрэглээг гол төлөв хур борооны усыг хуримтлуулах болон усны нөөцийг өөр бүс нутгаас тээвэрлэн хангахаар шийдвэрлэнэ. Харин хур тунадас элбэгтэй Европын орнуудад газрын доорх усны нөөцийг бараг ашигладаггүй зөвхөн ил задгай усны эх үүсвэрийг хуримтлуулан хэрэглээгээ хангадаг ажээ.

Гэтэл манай улсын гадаргын усны нөөц нь нийт усны нөөцийн 80 гаруй хувийг эзэлдэг боловч бүрэн ашиглаж чадахгүй байгааг доорхи жишээнээс харна уу:

- Гадаргын усны 95 орчим хувь нь гадагшаа Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дэвсгэр рүү урсдаг ба цас, борооны үерийн илүүдэл их хэмжээний усыг бид ашиглаж чаддаггүй;
- Гадаргын усны нөөцийн зөвхөн 5 хувь нь газар тариалан, үйлдвэрлэлийн хэрэгцээ, хүн, малын унданд болон бусад хэрэгцээнд ашигладаг байна.⁷

Шигтгээ: Уурхайн үс хэрэглээний норм

Нүүрснээс шингэн түлш гаргахад 9800 л/ тн, жоншны уурхайд 1 тоннд 1800л, цайрын уурхайд 1 тоннд 16000л, зэсийн хүдрийн уурхайд 1 тоннд 4900л, алт, цагаан тугалга олборлолт 1м³ элс угаахад 4100л, 1 тонн хүдэр боловсруулахад 4600л үс хэрэглэдэг гэх мэт норм байдаг байна.

Усны Үндэсний Төв 2010. <http://www.watercenter.mn/mn/news/139-interview3>

2.1.1. УСНЫ НӨӨЦИЙН ЗОХИСГҮЙ АШИГЛАЛТЫН ҮР ДАГАВАР

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт болон иргэд, аж ахуй нэгжүүд, байгууллагуудын усны зохисгүй хэрэглээ, мөн эрдэс баялагийн ашиглалтаас үүдэн гол горхи, нуур, цөөрөм олон тоогоор ширгэж алга болж байна. Тухайлбал, усны тооллогын дүнгээр манай оронд 2011 оны байдлаар 6646 гол горхи, 3613 нуур тойром, 10557 булаг, 265 рашаан тоологдсон. Гэтэл 551 гол, 483 нуур тойром, 1987 булаг шанд ширгэж алга болсон гэж бүртгэгдсэнээс дийлэнх нь ойт хээр, хээрийн бүсэд байжээ. Гол горхи, булаг шанд, нуур, тойром ширгэж байгаа нь хүн ам, ан амьтныг усны хомсдолд оруулж үлмаар хөрсний доройтол, цөлжилт үүсэх шалтгаануудын нэг болж байна. Өөрөөр хэлбэл, үс бол хүний үндсэн эрхтэй

⁷ “Байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглах, хамгаалах” олон нийт, иргэдэд зориулсан гарын авлага 2011

холбоотой учир онцгой бодлого шаардаж байдаг нөөц юм. 2006 оны Дэлхийн хүний хөгжлийн илтгэлд “Усны хомсдол нь ядуурал, тэгш бус байдлыг нэмэгдүүлж, улс орны эдийн засгийн хөгжил дэвшилд шууд сөргөөр нөлөөлөх бөгөөд хүнийг хөгжүүлэх үндсэн нөхцлүүдийг бүрдүүлэх боломжгүй болгож байна. Тиймээс цэвэр усны хүртээмж чанарын асуудал бол улс орон, хүний хөгжлийн гол асуудал байх ёстой” гэж заажээ.

Шигтгээ: Дундговь аймгийн Говь-Угтаал сумын иргэд, малчдын хамгийн тулгамдсан асуудал гадаргын усны хомсдол болжээ. Дундговь аймгийн Говь-Угтаал сумын “Хонгор Угтаал” Төрийн бус байгууллагынхны ярьснаар ... малчдын 90% нь усны хомсдолд ороод байна. Тэд малаа нэг удаа бөөнд нь усалдаг байсан бол одоо 4-5 хэсэг болгож усалдаг. Малаа маллаж, ашиг шимээр нь амьдралаа залгуулдаг малчид ус үндгүй, бэлчээр нутаггүй болчихвол хаачих вэ? Тус сумын малчдын яриагаар ... малаа услахын тулд 3-4 худаг дамжих заримдаа шөнө хагаслан малаа усалдаг байна.


“Монгол улсын хүний хөгжлийн илтгэл 2011”-д дүрдсанаас үзэхэд нэг хүнд 600 куб метрээс бага хэмжээний усны нөөц ногдож байвал усны үнэмлэхүй хомсдолд орсон гэж тодорхойлдог. Энэ тодорхойлолтын дагуу Говь-Алтай аймаг усны хомсдолтой, Орхон, Өмнөговь, Дорноговь, Улаанбаатар, Дархан-Уул, Сүхбаатар, Дундговь гэсэн долоон аймаг үнэмлэхүй хомсдолтой байна. Орхон, Хэнтий, Дорнод аймагт усны гурван эх үүсвэр тутмын хоёр нь хатаж ширгэсэн. Сүхбаатар, Өмнөговь, Өвөрхангай зэрэг аймагт 2007 онд усны гурван эх үүсвэр тутмын нэг нь ширгэсэн болох талаар өгүүлжээ.

Дэлхийн усны нөөц тогтмол байхад хүн амын тоо тасралтгүй өсөж байгаа нь усны хүртээмжийг улам багасгаж байгаа бөгөөд НҮБ-аас гаргасан баримтаар өдөрт 25-30 мянган хүн цангаж үхэж байгааг нотложээ⁸. Судлаачид хоёрхон арван жилийн дараа усны нөөц нь нефть, байгалийн хийгээс үнэтэй болж, улс орнуудыг амьд үлдэхийн төлөөх онцгой хэрцгий дайнд хүргэнэ гэж таамаглал дэвшүүлжээ. НҮБ-ын үндны усны асуудлаарх хөтөлбөрийн хүрээнд 2005-2014 оныг “Амьдралын эх сурвалж-Ус” гэсэн 10 жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зарласан бол Монгол улс 2011 оныг “Усны жил” болгон зарлаж байв.

Монгол улс усны нөөцөөрөө хязгаарлагдмал нөөцтэй орны тоонд ордог. Сүүлийн жилүүдэд манай улсын хүн ам болон эдийн засгийн өсөлт нэмэгдэж байна. Эдийн засаг хурдацтай өсөхийн хэрээр үндэсний үйлдвэрлэл эрчимжиж, хэрэглээний усны хэрэгцээ нэмэгдэж байгаа өнөө үед усыг зөв зохистой ашиглах усны нөөцийн менежментийн асуудал хурцаар тавигдаж байна.

⁸ www.academia.edu

Зураг 1. Усны ирээдүйн үнэ цэнэ



2.1.2 УСНЫ НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

Усны нөөцийн хариуцлагатай ашиглалт нь улс орон, иргэн бүрийн онцгой анхаарал хандуулах ёстой асуудал болов. Тэгвэл бид усны нөөцийг ариг гамтай ашиглахын тулд юу хийх ёстой вэ? Хариулт нь усны нөөцийн менежментийг талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх. Усны нөөцийн менежмент гэдэг нь усыг өмчлөгч (төрийн байгууллага) болон ашиглагч, хэрэглэгч (иргэд, малчид, бусад аж ахуйн нэгжүүд)-дийн усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалахтай холбоотой эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг үнэлэх, цаашид сайжруулахад шаардлагатай асуудлуудыг төлөвлөн зохион байгуулах үйл явц юм.

Монгол улсын “Усны тухай” хуульд, “Усны сав газар” гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг хэлнэ... гэж тодорхойлсон.



Шигтгээ: Туул голын сав газар

Нутаг дэвсгэр: Туул голын сав газар нь 5 аймгийн 37 сум, Улаанбаатар хотын 7 дүүргийн нутаг дэвсгэрийг хамран нийтдээ 49'774.3 км² талбайг эзэлдэг ба голын нийт урт 717 км. Туул голын сав газарт Улаанбаатар хотын эдэлбэр газрын 65.5%, Төв аймгийн газар нутгийн 39.8%, Булган аймгийн 20.8%, Өвөрхангай аймгийн 6.0%, Архангай аймгийн 4.4%, Сэлэнгэ аймгийн 2.2% нь тус тус хамрагдна.

Туул голын сав газарт: Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг; Архангай аймгийн Өгийнуур, Хашаат сум; Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл, Хархорин сум; Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум; Булган аймгийн Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Рашаант, Хишиг-Өндөр сум; Төв аймгийн Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баяндэлгэр, Баянцогт, Бүрэн, Заамар, Лүн, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаалцайдам, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод, Цээл, Аргалант, Баянхангай сумдын нутаг хамрагдана.

Хүн ам: 2010 оны байдлаар Туул голын сав газарт хамаарах аймаг, сумдад 1'191.9 мянган хүн оршин сууж байгаа нь Монгол улсын нийт хүн амын 42.8 хувь юм. Үүнээс 95.7 хувь нь нийслэл, аймгийн төвийн, 1.6 хувь нь сумын төвийн, 2.6 хувь нь хөдөөгийн иргэд байна.

Ус ашиглалт: Туул голын сав газар нь 2010 оны байдлаар 4000 гаруй жижиг, дунд үйлдвэр, давхардсан тоогоор 40 гаруй уул уурхай, 16 мянга гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг ба 170 мянган га бэлчээр, 2'951.2-2'853.5 мянган толгой малтай, төвийн эрчим хүчний системийн гол эх үүсвэрүүд болох дулааны гурван томоохон цахилгаан станц байршдаг Монгол орны бусад голын сав газруудтай жишихэд хамгийн олон ус хэрэглэгчтэй, газрын доорх усыг хамгийн их ашигладаг сав газар юм.

Эх сурвалж. Туул голын сав газрын захиргаа, www.tuulgol.mn.

Гол, мөрнүүдийн ай сав буюу тухайн мөрөн, гол, горхинд цас борооны ус цугларан орох боломжтой өндөрлөг газрын хяраар хүрээлэгдсэн талбайг ус хурах талбай гэнэ. Усны сав газар нь гол мөрнийг усаар тэтгэгч газрын судас болсон гол горхинуудаас бүрэлддэг ба тухайн сав газрын хөрс, ургамал, экосистемүүд нь өөр өөрийн гэсэн онцлог, үүрэгтэйгээр бие биетэйгээ харилцан хамааралтай оршдог. Тухайлбал, нэг уул нурууны ар өвөр талууд Төв азийн гадагш урсгалгүй болон Хойд мөсөн далайн ай савд хуваагдаж, нэг дор оршин байх боловч хоёр өөр усны сав газарт харъяалагдах ба тухайн сав газарт амьдардаг хүмүүс ба талуудын амьдрал ахуй нь тэр сав газрын усны нөөцөөс адилхан хамаарах жишээтэй. Усны нөөцийн ашиглалтыг зөв зохистой, нэгдсэн байдлаар хамгаалах, үйл ажиллагааг зохион байгуулж явуулахын тулд усны нөөцийн нэгдсэн менежментийг боловсруулах явцад тухайн сав газарт хамаарагдах аймаг, сумууд болон бусад хэрэглэгч талууд идэвх санаачлагатай оролцох, сав газрын менежментийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих нь чухал юм.

Иймд тухайн сав газрын менежментийн төлөвлөгөөнд бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудлыг давхар тусган төлөвлөхдөө усны нөөцийг ашиглагч болон

өртөгч талуудын асуудлуудыг тусгаж өгөх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Мөн тухайн голын сав газрын усны нэгдсэн нөөцийн менежментийн төлөвлөгөөг зэргэлдээ орших сав газрын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах нь нэг сав газраас нөгөө сав газарт үзүүлэх нөлөөллийг тодруулан авч үзэхэд дөхөмтэй.

Монгол орон физик, газарзүйн байршил болон гадаргын ус, газрын доорх усны нөөц, шилжилт хөдөлгөөн зэргээс хамаарч нийт 29 сав газарт хуваагддаг бөгөөд тухайн сав газрын талбайн хэмжээ, түүн доторх гол, мөрний урсац бүрэлдэхэд чухал газар нутаг, голын татам, нуга зэргийн хэмжээ нь харилцан адилгүй юм.

Тиймээс, бүс нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо тухайн голын сав газар тус бүрийн ашиглаж болох нийт усны нөөцийн (гол, мөрөн, нуур цөөрмийн болон газрын доорхи хуримтлагдсан) хэмжээг харгалзан үзэж усны нөөцийн хомсдолд оруулахгүй байх хэмжээнд ашиглах нь чухал.

Монгол улсын “Усны тухай” хуульд, “Сав газрын захиргааны дэргэд сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, олон талын оролцоог хангах үүрэг бүхий орон тооны бус усны сав газрын зөвлөлийг байгуулна” гэж заасан байдаг. Одоогийн байдлаар, манай улсад томоохон гол мөрний сав газрыг хамарсан 29 сав газрын захиргаа байгуулагдан ажиллаж байна. Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн сав газарт хамрагддаг сум дүүргийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, төрийн бус байгууллага, сум, дүүргийн иргэд, ус ашиглагч байгууллага, эрдэмтэн, судлаач, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орно.



Шигтгээ: Туул голын сав газрын зөвлөл.

Туул голын сав газрын зөвлөл нь Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн нөөц, хэрэглээ, ашиглалт, хэтийн төлөв, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх зорилготой. Сав газрын зөвлөл нь 45 гишүүнтэй. Засаг захиргаа болон иргэний төлөөлөл 10, байгаль орчин, мэргэжлийн хяналт, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл 10, ус ашиглагчид болон мэргэжлийн холбоодын төлөөлөл 10, төрийн бус байгууллагын төлөөлөл 10, эрдэмтэн судлаачдын төлөөлөл 4, хэвлэл мэдээллийн төлөөлөл 1 хүний бүрэлдэхүүнтэй. Тус сав газрын зөвлөл нь Усны тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу дараах эрхтэй байна. Үүнд:

- Ус хамгаалах, зохистой ашиглах шийдвэр гаргахад иргэдийн саналыг тусгуулах;
- Усны нөөцийг хуримтлуулах, ашиглах, томоохон уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх болон далан, суваг барих төсөлд санал өгөх;
- Сав газрын захиргааны усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах шийдвэр гаргуулах, хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх зэрэг эрхтэй.

Хүлээх үүрэг:

- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн мөрдөлтөнд хяналт тавих;
- Урсац бүрэлдэх эх, усны эх үүсвэрийн орчмыг хамгаалах, ойжуулах, тохижуулах, нөхөн сэргээх арга хэмжээг нутгийн иргэдийн дэмжлэг, санаачлага, мэргэжлийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах;
- Усны барилга байгууламжийн зураг төсөл, усны нөөцөд сөрөг нөлөөтэй нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдвал барьж байгуулах ажлыг түдгэлзүүлэх саналыг эрх бүхий байгууллагад гаргах,

Эх сурвалж: Туул голын сав газрын захиргаа. www.tuulgol.mn




2.2. ХӨРС

Хөрсөн бүрхэвч нь тухайн бүс нутгийн ургамлан нөмрөг, ан амьтан зэрэг байгалийн нөөцүүдэд хэрэгтэй эрдэс, шим тэжээлийг агуулж байдаг байгалийн нөөцийн нэг төрөл юм. Өөрөөр хэлбэл, байгаль дахь бодис, энергийн харилцан үйлчлэлийг зохицуулах, тэнцвэржүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн газрын хөрсөнд агуулагдаж буй эрдэс, органик нэгдлүүд нь хөрсний бүтэц, түүний балансыг тохируулж, улмаар хөрсний дулааны болон чийгийн горимыг зохицуулж, тухайн хөрсний ялзмагт үе давхаргыг урт хугацаанд нэгэн хэв шинжийг хадгалж өгдөг. Монгол оронд хүрэн, хар хүрэн, хар шороон, нугын хүрэн, говийн бор, цөлийн бор саарал, нуга намгийн болон мараалаг, давсархаг зэрэг хэв шинжийн хөрс байдаг. Эдгээрээс хамгийн түгээмэл тархсан нь хүрэн шороон хөрс бөгөөд нийт нутгийн 40.4 хувийг эзэлнэ. Монгол орны газрын хөрсний онцлог нь хатуу ширүүн уур амьсгалаа дагаад маш нимгэн эмзэг байдаг. Ялангуяа говь, тал хээрийн бүсэд хөрс нь нэн эмзэг. Тухайлбал, говийн бор хөрсний дундаж зузаан нь 5-10 см, дундаж их хэмжээ нь 27 см хүртэл байдаг онцлогтой. Иймээс манай орны газрын хөрс маш удаан хугацаанд нөхөн сэргээгддэг нөөц, үнэт байгалийн баялаг юм. “Эрүүл хөрс-Эрүүл хүнс”.

ХӨРСНИЙ ҮҮРЭГ

Хүн амын амьдарч байгаа нутаг дэвсгэрийн эрүүл ахуйн байдлыг илтгэн тодорхойлдог гол хүчин зүйл нь хөрсөн бүрхэвч бөгөөд хүний амьдрах орчин болон хүрээлэн буй орчинд хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүн амьтны хүнс тэжээлийн ургамлыг ургуулах орчныг хангаж өгдөг;
- Ургамал амьтны амьдрах орчин болно;
- Нүүрстөрөгчийн давхар ислийг үйлдвэрлэж хадгалдаг;
- Дулаан болон чийглэгийн горимыг зохицуулж байдаг;
- Ус, хог хаягдлыг шүүж хоргүйжүүлдэг;
- Барилга, эм зүй, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн түүхий эд, материал болдог;



- Хаягдал ялзрах орчин болдог;
- Геологи, уур амьсгал, биологи, хүний түүхийн үл мөрийг хадгалж байдаг билээ.

2.2.1. ХӨРСНИЙ ДОРЙТОЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Хөрс үржил шимт чанараа алдах үйл явцыг хөрсний доройтол гэж нэрлэдэг. Доройтолд орсон хөрс нь ургамалд хэрэгтэй шим тэжээлээр болон чийгээр хангах чадвараа алддаг.

Хөрсний доройтол нь хөрсний эвдрэл, хөрсний бохирдол, хөрсний үр шим буурах гэсэн үндсэн 3 хэлбэрээр илэрнэ. Байгалийн чадавхийн тогтсон хэм хэмжээнээс хэтрүүлэн хөрс нь өөртөө хорт бодисыг шингээж задлах чадавхиа алдан улмаар газрын доорхи болон гадаргын ус, ургамал, амьд организмыг хордуулж эхлэхийг хөрсний бохирдол гэдэг.

Монгол улсын хэмжээнд хөрсний доройтолд орсон газрын хэмжээ аймаг бүрт харилцан адилгүй. Гэхдээ хүн ам шигүү суурьшсан хот суурин газар, газар тариалангийн бүс, уул уурхайн хайгуул, олборлолт явуулж буй газар, дэд бүтэц хөгжсөн, усан хангамж сайтай газрууд илүүтэй өртөж байгаа нь ажиглагджээ. Монгол улсын Газрын нэгдмэл сангийн 2010 оны нэгдсэн тайланд ... *2010 оны байдлаар 7359.7 мян га газарт экологийн хохирол учирсан байна. Үүнээс 6.8 сая га бэлчээр (Нийт газрын 92.1 хувь) , 375.7 мян га ойн сан бүхий газар (5.1 хувь), 184.5 мян га газар газар тариалангийн газар (2.5 хувь), 8543.9 га хот тосгон бусад суурингийн газар (0.1 хувь), 935.9 га усан сан бүхий газар (0.01 хувь), 19419 га газар ухагдаж эвдэрсэн (0.5 хувь) зэрэг шалтгааны улмаас хөрсний доройтолд өртсөн болохыг дурджээ.*

Манай орны хөрсний доройтолд байгалийн, хүний гэсэн хоёр үндсэн хүчин зүйл нөлөөлдөг. Хөрсний доройтолд нөлөөлдөг байгалийн хүчин зүйлд ган, үер, хүчтэй салхи, хөнөөлт мэрэгч, хортон шавьж, элсний нүүдэл орно. Харин хүний хүчин зүйлд төлөвлөлтгүй хот суурин газар, хог хаягдал, замбараагүй зам харгүй, мал аж ахуй, газар тариалан, ой мод, уул уурхайн үйлдвэрлэлийн ашиглалт ордог.

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний элэгдэл, эвдрэл болон бохирдлын хэмжээ нь байгалийн хүчин зүйлсийн нөлөөллөөс хавьгүй илүү байна. Хүний хүчин зүйлээс хамааралтай хөрсний доройтол үүсгэж буй шалтгааныг авч үзвэл:

Асуудлууд	Нөлөөлөгч гол хүчин зүйлс
Хөрсний үржил шим буурах, бүтэц эвдрэх, ашигт бичил биетэн устах	Иргэд аж ахуйн нэгжүүд газрыг гүн, хэт их хагалснаас хөрсний бүтэц эвдрэх, борооны усаар хөрс угаагдан органик бодис нь алдагдах, нэг төрлийн ургамлыг сэлгээгүй дагнаж тарьснаас хөрсний үржил шим буурах, хог ургамал, хортон шавьж устгахад химийн бодис хэрэглэснээс хөрсний ашигт бичил биетнийг устгах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлжээ.
Бэлчээрийн талхагдал	Төрөөс малчдын талаар явуулж буй бодлогод экологийн асуудал орхигдуулсан. Үр дүнд нь бэлчээрийн талхагдал нэмэгдэв. Малын хөлд хөрс талхагдсанаас чийг барих, ургамлын ургалтыг дэмжих чадвар нь алдагдаж буй нь эрдэмтдийн судалгаагаар нотлогдсон.
Хөрсний бохирдол	Хот суурин газарт шилжих хөдөлгөөн ихсэж хүн амын тоо өсч байгаа нь хөрсний бохирдлыг нэмэгдүүлж байна. Жишээ татахад нийслэл Улаанбаатар хотын хөрсний бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин илүү гэж судлаачид үздэг. Ил задгай хог хаягдал хаях, угаадас асгах, гэр хорооллын айлуудын ил жорлон, үйлдвэрийн утаа, утаа тортог, нарийн ширхэгтэй үнс, тоосонцор зэрэг нь хөрс бохирдох гол шалтгаан болжээ.
Хөрс чийг барих чадвараа алдах	Ой мод нь хөрсийг хамгаалж чийгийг барих үүрэгтэй. Гэтэл хүмүүсийн зохисгүй ашиглалт нь ой модны нөөцийн хомсдлын гол шалтгаан болов. Тодруулбал модыг түлшний болон ахуйн хэрэглээнд зориулж, хулгайгаар бэлтгэдэг, ойн түймэр, хортон шавьжийн хөнөөл зэрэг нь хомсдолыг нөхцөлдүүлж байна. Судлаачдын тогтоосноор модыг нь огтолсон газарт хөрсний ус шингээх чадвар 65-70 хувь, хөрсний ялзмаг 9-30 хувь буурч, хөрсний тогтворжилт 15-50 хувь багасдаг болохыг тогтоожээ.
Хөрс эвдрэх	Уул уурхайн үйл ажиллагаа нь нүх ухах, хөрсийг гэмтээхээс гадна хөрсөн доорх эрдэс, шороог ил гарган агаарт олон төрлийн химийн хорт бодис уурших нөхцлийг бүрдүүлдэг. Химийн хорт нэгдлүүд хөрсөнд их концентрацтай орвол хөрсний өнгөн давхарга амархан бохирдож, хөрсний организмуудыг хөнөөдөг. Үүний үр дүнд хөрсөнд өөрийгөө цэвэршүүлэх чадвар алдагдаж, хүн амьтан, ургамалд ихээхэн хортой нөлөө үзүүлнэ. Мөн уул уурхайн компани нөхөн сэргээлтийг дутуу хийсэнтэй холбоотойгоор бичил уурхай эрхлэгчид тухайн газарт дахин олборлолт хийх, үүндээ мөнгөн үс гэх мэт химийн хорт бодис ашиглан хөрсийг бохирдуулах нь түгээмэл ажээ ⁹ .

Хөрс бохирдсоноор хөрсөн дэх химийн шинж чанар өөрчлөгдөж, улмаар геобиохимийн өөрчлөлт явагдан ургамлын биомасс болон газрын доорх усыг бохирдуулах зэрэг сөрөг нөлөөллүүд үүснэ.

⁹ www.bolod.mn

Монгол улс газрын доройтолтой нутагт амьдарч буй хүн амын хэмжээгээр дэлхийн 150 орны 12-т жагсдаг бөгөөд Африкийн 10 –н орны ард орж байна¹⁰. Хөрс, газрын доройтол нь тухайн нутагт амьдарч буй хүмүүсийн эрүүл мэнд, орлого олох эх үүсвэрт шууд сөргөөр нөлөөллөг. Тухайлбал, газрын доройтлоос үүдэн шороон шуурганы давтамж ихсэж байгаа бөгөөд¹¹ энэ нь хүн амьсгалахад хүндрэл учруулж улмаар уушигны үрэвсэлт өвчинд өртөх эрсдлийг нэмэгдүүлж, халдварт өвчин тархах нөхцлийг бүрдүүлж байна.

“Монгол улсын хүний хөгжлийн илтгэл 2011”-д “Говь цөлийн бүс нутаг өвөлдөө цасгүй буюу цасан бүрхэвч нимгэн, зундаа бороо хангалттай ордоггүй, хөрс хуурайшсан, хөрсөн дэх элсний агууламж нэмэгдсний улмаас ургамал ногоо бага ургаж, хөрс салхинд хийсэн замхарч байна. Нэг талаас хүний үйл ажиллагаатай холбоотойгоор малын нэг төрлийг дагнан өсгөх, бэлчээрийн даацыг хэтрүүлэх, нөгөө талаас уул уурхайн үйл ажиллагаа газрын доройтолд нэрмээс болж байна” гэж тэмдэглэжээ.

2.3. БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

Эрдэс баялаг нь газрын хэвлийд байхдаа агаар, усны тэнцвэрийг хадгалан зохицуулж байдаг онцлогтой. Харин түүнийг газрын хөрсөн дээр гаргахад төрөл бүрийн химийн хорт бодис агаар мандалд тархан байгалийн тэнцвэрийг алдагдуулдаг. Үүний нотолгоо нь уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй газар нутагт ургамал, ан амьтдын төрөл зүйлийн тоо хэмжээ хорогдож буй явдал. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь доорх сөрөг үр дагавар бүхий өргөн хүрээтэй нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Уурхайн ашиглалтын зөвшөөрөлтэй талбайн зам, ус дамжуулах шугам хоолой, усны цооногийн талбай болон үйлдвэрлэлийн барилгын ажлаас үүдэн амьдрах орчин урт хугацаанд эсвэл бүрмөсөн алдагдах;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсч, ургамлан бүрхэвчийг доройтуулах, хогийн ургамал тархах, дуу чимээ ихэсч, тайван бус байдал нэмэгдэх, зэрлэг амьтдын нүүдэлд саад учруулах, амьдрах орчны хуваагдал үүсэх;
- Аюултай бодис ба хог хаягдлын асуудлыг зөв зохистой шийдэхгүй тохиолдолд хөрс, ус, агаар бохирдох;
- Гүний усны түвшин өөрчлөгдөх буюу татарснаар амьтан ба ургамлын амьдралыг тэтгэдэг усны нөөцөд нөлөөлөх;
- Бэлчээр доройтолд орох.

¹⁰ Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл 2011, 48-р тал

¹¹ Монгол улсын Хүний хөгжлийн илтгэл 2011, 30-р тал

2.3.1. БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМУУД

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөг үнэлэх, нөлөөллөөс зайлсхийх, нөлөөг бууруулах, арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, байгаль орчныг хамгаалах нэмэлт ажлууд зохион байгуулах цогц үйл ажиллагаа нь биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах үндсэн арга зам юм. Дэлхийн улс орнууд, банк санхүүгийн байгууллагууд нэгдсэн бодлого, аргачлал, зарчимд тулгуурлан уул уурхайн төслүүдийг санхүүжүүлэх эсэхээ шийддэг болжээ. Энэ нь цаашид үүсэж болох эрсдэл, үл ойлголцлоос сэргийлэн, хүримтлагдах нөлөөлөл болон нийгмийн хариуцлагыг бүрэн хэрэгжүүлэх зорилготой холбоотой. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн сөрөг нөлөөллийг бууруулахад “Сөрөг нөлөөлөл бууруулах шатлалын тогтолцоо” баримтлана. Үүнд: Юуны өмнө үндсэн суурь судалгаа, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийх. Эдгээр судалгаа, тайлангийн мэдээлэл нь цаашдын сөрөг нөлөөг бууруулах үе шатуудын бүхийл үйл явц, шийдвэрт ашиглагдах үндсэн мэдээлэл болох юм.

1. Сөрөг нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх
2. Сөрөг нөлөөллийг багагасгах, хамгийн бага байлгах
3. Нөхөн сэргээлтийг хийх
4. Дүйцүүлэн хамгаалах: Энэ үе шатыг хэрэгжүүлэхдээ 10 зарчмыг заавал мөрдөх хэрэгтэй.

Сөрөг нөлөөлөл бууруулах шатлалын тогтолцоо



Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах 10 зарчим

Дүйцүүлэн хамгаалах гэдэг нь төсөл боловсруулахтай холбоотойгоор биологийн төрөл зүйлд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авсны дараагаар үлдсэн нөлөөлөл, хохирлыг нөхөн төлөх зорилгоор авч хэрэгжүүлж буй байгаль хамгаалах арга хэмжээний үр дүнг хэлнэ. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний үндсэн зорилго нь цэвэр алдагдлыг тэглэх буюу биологийн олон янз байдал түүний төрөл зүйлийн бүрдэл, амьдрах орчны бүтэц, экосистемийн үүрэг функц, хүмүүсийн хэрэглээ болон биологийн олон янз байдалтай холбоотой соёлын үнэт зүйлс зэргийг хамгаалахад оршино.

Эдгээр зарчмууд нь биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлэх үндэс суурийг тавихын зэрэгцээ тэрхүү үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулдаг. Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үндэсний болон олон улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж Биологийн төрөл зүйлийн талаарх үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасанчлан Биологийн төрөл зүйл түүний экосистемийн тухай конвенцитай уялдуулан төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгтэй.

1. **Нөлөөллийг бууруулах шатлалыг дагаж мөрдөх:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах гэдэг нь нөлөөллийг бууруулах шатлалын дагуу нөлөөллөөс ЗАЙЛСХИЙХ, бууруулах, нөхөн сэргээх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дараа биологийн төрөл зүйлд учруулж буй сөрөг нөлөөллийн хохирлыг дүйцүүлэн арилгах зорилго бүхий үйл ажиллагаа юм.
2. **Дүйцүүлэн хамгаалах боломжгүй нөхцөл:** Зарим тохиолдолд үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах замаар нөхөх боломжгүй байдаг. Учир нь тухайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн биологийн төрөл зүйл орлуулашгүй буюу хэт эмзэг байдаг.
3. **Газрын төрх байдал, нөхцөл:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалахдаа биологийн төрөл зүйл түүний бүрэлдэхүүн экосистемийн биологи, нийгэм, соёлын ач холбогдлын талаарх өргөн цар хүрээтэй мэдээллийг харгалзаж үзсэний үндсэн дээр хүлээгдэж буй үр дүнг бий болгох боломжтой буюу газрын төрх байдал, нөхцлийн хувьд төсөөтэй газрыг сонгох нь чухал.
4. **Цэвэр алдагдал тэг байх:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхдээ тухайн газарт хэмжигдэхүйц

үр дүнд хүрэх буюу цэвэр алдагдлыг тэглэх, аль эсвэл биологийн төрөл зүйлийн хувьд цэвэр ашгийг бий болгох зорилгоор хэрэгжүүлнэ.

5. **Байгаль хамгаалах нэмэлт үйл ажиллагаануудын үр дүн:** Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх байгаль хамгаалах арга хэмжээний үр дүн нь дүйцүүлэн хамгаалаагүй үеийнхээс илүү үр дүнтэй байх учиртай. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дизайн болон хэрэгжилтийн хувьд тухайн газраас өөр газрын биологийн төрөл зүйлд хохирол учруулахаас зайлсхийх хэрэгтэй.
6. **Талуудын оролцоо:** Төслийн болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн газруудад биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах тэр дундаа тухайн үйл ажиллагааг үнэлэх, сонгох, боловсруулах, хэрэгжүүлэх мөн хяналт тавих талаар шийдвэр гаргахад талуудын оролцоог хангах хэрэгтэй.
7. **Эрх, тэгш байдал:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалахдаа эрх, тэгш байдлыг хангах хэрэгтэй. Үүнд оролцогч талуудын эрх, үүргийн хуваарилалт, төсөл болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, урамшуулал зэргийг хууль, журмын хүрээнд шудрага, тэнцвэртэй хуваарилах нь зүйтэй. Олон услын болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн уугуул болон орон нутгийн иргэдийн эрх, ашгийг хүндэтгэх талаар онцгойлон анхааран авч үзэх хэрэгтэй.
8. **Урт-хугацаанд гарах үр дүн:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг боловсруулан, хэрэгжүүлэхдээ ДАСАН ЗОХИЦОХ МЕНЕЖМЕНТИЙН арга барилд үндэслэх хэрэгтэй. Ингэхдээ, төслийн нөлөөллийг бүрүүлэх хэмжээнд үргэлжлэх, болж өгвөл ӨНӨ УДААН хугацаанд үргэлжлэх үр дүнг бий болгох зорилго бүхий ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ системийг мөн тусгах шаардлагатай.
9. **Ил тод байдал:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхдээ, мөн түүний үр дүнг олон нийтэд цаг тухайд нь нээлттэй, ил тод мэдээллэх хэрэгтэй.
10. **Шинжлэх ухаан ба уламжлалт арга ухаан:** Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг боловсруулан, хэрэгжүүлэх үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр баримтжуулахын зэрэгцээ уламжлалт арга, ухааныг мөн харгалзан үзэх нь зүйтэй.

Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн энэхүү менежментийн үр дүнд бүс нутгийн хэмжээнд биологийн олон янз байдал одоогийн нөхцлөөсөө илүү сайжирсан, хамгаалагдсан, тоо толгой нь хэвийн байгаа эсэхэд орон нутгийн иргэд гол анхаарлаа хандуулдаг.

Тодорхой дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийхдээ тухайн орчныг нөхөн сэргээдэг ч эргээд яг эхний байдлаар нь үлдээх боломж тун хязгаарлагдмал. Тиймээс үйлдвэрлэл явуулсан, байгууламж баригдсан газруудыг анхны хуучин хэвэнд нь оруулахгүй ч аль болох сөрөг нөлөөг нь бууруулах, унаган төрхөнд нь ойртуулах нөхөн сэргээлт хийдэг. Нөхөн сэргээлт хийсний дараа үлдээд буй сөрөг нөлөөг яах вэ гэдэг асуудал гарч ирнэ. Иймд орон нутагт байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санаачлан зохион байгуулах, санхүүжилт болоод бусад бүх талаар дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг дүйцүүлэн хамгаалах гэж хэлдэг. Дүйцүүлэн хамгаалах газар нутаг, байгаль орчин нь тухайн уул уурхайн сөрөг нөлөөлөлд автаад байгаа газар нутагтай ойролцоо байх ёстой. Говьд уул уурхайн үйл ажиллагаа явуулчихаад хангайд ан амьтан үржүүлээд бид дүйцүүлэн хамгаалах ажлыг амжилттай хийсэн гэж болохгүй.

Зэрлэг ан амьтан тухайлбал, уулын болон тал хээрийн туруутан, шувууд, жижиг хөхтөн, мөлхөгчид, усан орчны шавьж ба хоёр нутагтан, хуурай газрын шавьж зэргийн тооллого, судалгааг тодорхой давтамжтайгаар уул уурхайн төсөл хэрэгжиж буй газар нутаг, нөлөөлөлд өртөөгүй газар нутагт тогтмол хийх шаардлагатай. Мэдээж үүнд мэргэжлийн хүмүүстэй хамтрахаас гадна нутгийн иргэдийг арга зүй, багаж хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр ханган оролцуулах нь чухал юм. Ингэснээр орон нутгийн биологийн төрөл зүйлийн олон янз байдалд учирч болзошгүй сөрөг нөлөөг үнэлэх, нөлөөллөөс зайлхийх, нөлөөг бууруулах, арилгах, нөхөн сэргээх ажлыг хамтдаа төлөвлөх, хэрэгжүүлэх боломжийг олгох олон давуу талтай. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бүтээгдэхүүнээ тээвэрлэх замын дэд бүтэц байгуулахдаа зэрлэг амьтдын амьдрах газар нутгийг хуваахгүй байх, саадгүй бас аюулгүй байдлаар зам хөндлөн нэвтрэх гарц, түр гармуудыг байгуулж өгөх хэрэгтэй.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлдэг байгууллагуудаас биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой амжилтанд хүрч буй гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай компаниуд байна.

Шигтгээ: Биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар Оюу толгой ХХК-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Тус компани нь уул уурхайн төсөлтэй холбоотойгоор тухайн бүс нутгийн биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөөс зайлсхийх зорилгоор болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, компанийн биологийн олон янз байдлын судалгааны баг говийн бүсийн хөрсөнд тохирсон нөхөн сэргээлтийн арга аргачлалыг тодорхойлох туршилт, судалгааны ажлыг 2003 оноос хойш хийж иржээ. Энэ ажлын хүрээнд шимт хөрс хуулах, хадгалах, говийн бүсэд дасан зохицсон нутгийн унаган ургамлыг нөхөн сэргээлтэнд ашиглах, үрийн нөөц бүрдүүлэх, ховор болон нэн ховор ургамлыг тарималжуулах, хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Ханбогд сумын нутагт 5 га-д мод үржүүлгийн газар байгуулсан. Уг газарт Солонгос улсын өндөр технологийн дагуу үйлдвэрлэгдсэн давхар ханатай, өвөл дотроосоо халдаг, усалгааны системтэй хүлэмж барьжээ. Хүлэмж нь мод үржүүлгийн газар биологийн нөхөн сэргээлтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэсэг болох юм. Мөн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах зэрэг байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээнүүдийг говийн бүсэд төлөвлөн хэрэгжүүлж эхэлсэн.

Шувуу, зэрлэг ан амьтан, ургамлын мониторинг хийж байгаа ба Оюу толгойн үүрхайгаас гарч орох бүх цахилгааны шугам, шонд шувуу чиглүүлэгчийг байршуулсан, төслийн талбайгаас БНХАУ-ын хил хүртэлх авто замыг зэрлэг ан амьтад ямар нэг аюулгүй байдлаар хөндлөн гарах гарц, цэгүүдийг байгуулжээ. Энэ бүх үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр дүнг биологийн төрөл зүйлд хэр зэрэг эерэг нөлөө ахиу үзүүлсэн байдлаар хэмжих юм байна.

Эх сурвалж: Оюу толгой ХХК-ийн орон нутгийн сонин

2.3.2. **БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ**

Монгол улс нь биологийн төрөл зүйлүүдийн амьдрах орчин болон тэдгээрийг хамгаалахад чиглэсэн олон улсын хэд хэдэн байгаль орчны гэрээ хэлэлцээр ба протоколд нэгдэн орсон. Тухайлбал, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай Конвенц”, “Цөлжилттэй тэмцэх Олон улсын Конвенц”, “Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын тухай Конвенц”, “Европын Зэрлэг амьтад ба амьдрах орчныг хамгаалах тухай Конвенц”.



Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн стандарт


“Гүйцэтгэлийн стандарт 6” нь төслийн үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлийн олон янз байдлын бүх түвшинд үзүүлэх нөлөөллийн зэрэглэлийн үнэлгээг нийгэм, байгаль орчны үнэлгээний үйл явцын салшгүй хэсэг болгон биологийн төрөл зүйлд учрах аюул эрсдэл, амьдрах орчны сүйтгэл болон гадны төрөл зүйлүүдийн нөлөөллийг онцгойлон авч үздэг ажээ. Энэхүү гүйцэтгэлийн стандарт нь биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах, байгалийн баялагийг тогтвортой байдлаар ашиглах явдлыг дэмжих зорилтуудыг агуулсан. Уг стандарт нь нөлөөллийг бууруулах арга хэмжээг биологийн төрөл зүйлүүдийн олон янз байдлыг “цэвэр алдагдалгүй” байлгах, нөлөөллийг багасгах буюу нөхөн төлбөр олгохоос илүүтэйгээр нөлөөллөөс зайлсхийх буюу урьдчилан сэргийлэх байдлаар төлөвлөн хийх ёстой гэдгийг онцолдог байна.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Гүйцэтгэлийн шаардлага

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны “Гүйцэтгэлийн шаардлага 6” нь биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, бууруулах мөн шаардлагатай үед биологийн олон янз байдлыг “цэвэр алдагдалгүй” байлгах зорилгоор их хэмжээний үлдэгдэл нөлөөллийг нөхөн хамгаалах зорилтуудыг дэвшүүлдэг. Гүйцэтгэлийн шаардлага 6-д амьдрах орчны төрлийг (аюултай, байгалийн, өөрчлөгдсөн, хамгаалагдсан буюу тогтоогдсон гэж) тодорхойлохыг шаарддаг бөгөөд амьдрах орчны төрөл бүрд зориулсан бүтээн байгуулалтын хязгаарлалт, шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

2.4. БЭЛЧЭЭР

Монгол орон олон зууны туршид нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч ирсэн өвөрмөц түүхтэй. Нүүдлийн мал аж ахуйн амин сүнс нь малын бэлчээр нутаг бөгөөд бэлчээрийг зөв зохицтой ашиглах, хамгаалах арга ухааныг хөгжүүлж, баяжуулж ирсэн уламжлалтай ард түмэн юм. Өвөг дээдсээс уламжилж ирсэн



бэлчээрийг ашиглах, хамгаалах арга ухаан нь аливаа бэлчээрийг өвс ургамал нь дахин нөхөн ургах хүртэл ашиглахгүй байх үүднээс жилийн дөрвөн улиралд бэлчээрийн даацад тохируулан байнга сэлгэн сольж нүүдэллэхэд үндэслэнэ. Энэхүү арга ухаан нь харьцангуй хуурай сэрүүн үүр амьсгалтай эмзэг хөрстэй Монгол орныг бэлчээрийн талхагдал доройтолд оруулалгүйгээр хорьдугаар зууны дунд үеийг хүргэсэн байна. Гэвч хорьдугаар зууны хоёрдугаар хагасаас энэ уламжлал гээгдэж, хотжилт, атар газар эзэмших аян, эрдэс баялаг олборлох зэрэг олон үйл явдал эрчимтэй өрнөж хөрсөнд сөргөөр нөлөөлж эхлэв.

Төлөвлөгөөт эдийн засгийн үед малын бэлчээрийг захиргаадалтын аргаар буюу хатуу зохион байгуулалтаар зохицуулж ирсэн байдаг. Зах зээлийн нийгэмд шилжсэнээр газрын тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд тус хуульд ... “Мал амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг бэлчээр гэнэ” гэж тодорхойлсон. Гэхдээ бэлчээрийг зохицуулах хууль эрх зүйн орчин өнөөдөр тун хангалтгүй байна.

2.4.1. Бэлчээрийн зохисгүй ашиглалт ба үр дагавар

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн тодорхойлолтыг үндэслэн тооцвол Монгол улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх магадлалтай нутагт хамрагдах бөгөөд үнэлгээ, зураглалын өнөөгийн үр дүнгээр цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэлд 5.0 хувь, хүчтэй зэрэглэлд 18.0 хувь, дунд зэрэглэлд 26.0 хувь, сул зэрэглэлд 23.0 хувь нь тус тус хамрагдах болжээ (“Монгол улсын цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” 2009). Газрын доройтол болон цөлжилт нь хүний эрх чөлөө болон сонголт хийх боломжийг хязгаарладаг.

Бэлчээрийн талхагдал нь уур амьсгалын өөрчлөлт, хүр тундасны жигд бус байдал, ган, хүчтэй шороон шуурга болон хүн ам, мал сүргийн бөөгнөрлөөс шалтгаалж, бэлчээрийн ургамлын биомасс хомсдох үзэгдэл юм. Монгол орны 128.3 сая га талбай бүхий бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр талхагдалд орсноос ургамлын бүрхэвч ядуурч, мал сүргийн тодорхой хэсэг бэлчээргүйдэн улмаар малын ашиг шим буурч байна. Энэ баримт бэлчээрийг хэрхэн ашиглаж байгааг харуулсан бодит нотолгоо гэхэд болно. Бэлчээрийн доройтлыг үүсгэхэд хүний хүчин зүйл, байгалийн хүчин зүйл гэсэн 2 үндсэн шалтгаан нөлөөлжээ. Хүний хүчин зүйлээс хамааран бэлчээрийг доройтолд оруулсан шалтгаанд: малын тоо толгой өссөн, үүний улмаас сүргийн бүтэц алдагдсан, бэлчээр ашиглаж ирсэн уламжлалыг орхигдуулсан, бэлчээрийг зохицуулах эрх зүйн орчин хангалтгүй, үүл уурхайн үйлдвэрлэл орно. Харин байгалийн хүчин зүйлд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарал ордог.

Бэлчээрт одоогийнх шиг хайхрамжгүй хандах юм бол хэдэн жилийн дараа мал бэлчээх газаргүй болох бодит аюул нүүрлэх нь. Бэлчээр байгалийн жамаар сэргэхэд дор хаяж 10 жил шаардлагатай. Нэг шоо метр талбайд 20 гаруй төрлийн ургамал ургадаг. Хэрвээ бэлчээр талхагдалд орсон тохиолдолд 1-2 зүйлийн ургамал ургана. Тиймээс 20 гаруй зүйлийн ургамал ургахын тулд олон жил шаарддаг. Хэдийгээр байгалийн хүчин зүйл нөлөөлж байгаа ч хүний бүрүүтэй үйл ажиллагаанаас бэлчээрийн талхагдал доройтол үүсч улмаар цөлжих явцыг түргэсгэж байгааг ч анхаарах хэрэгтэй.

2.4.2. БЭЛЧЭЭРИЙН НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ АШИГЛАЛТ

Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үндсэн арга бол бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлэх явдал юм. Сумын засаг захиргаа, малчид, малчдын бүлэг, хоршоо, байгаль хамгаалах төрийн бус байгууллагууд хамтран орон нутгийнхаа бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих цогц үйл ажиллагааг бэлчээрийн хамтын менежмент гэнэ. Бэлчээрийн хамтын менежментийн үр дүн нь а. бэлчээрийн хяналт, үнэлгээ, б. бэлчээрийн мэдээлэл, в. бэлчээр ашиглалтын төлөвлөлт гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүн хэсгийг зөв оновчтой зохион байгуулж хэрэгжүүлэхээс шууд хамаардаг.

Бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөө боловсруулах

Бэлчээрийн хамтын менежментийг боловсруулан хэрэгжүүлэх нь тухайн бэлчээрийн нөөц, чадавхийг бүрэн ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс урьдчилан сэргийлэх, даван туулах арга хэмжээг эртнээс зохион байгуулах бололцоог олгодог.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндсэн найман үе шаттай боловсруулдаг. Үүнд:



Сумын түвшинд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахын тулд малчид, мал бүхий иргэд, малчдын бүлэг, малчдын хоршоо, байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан “Бэлчээрийн хамтын менежмент”-ын талаар мэдлэг ойлголт өгөх сургалт зохион байгуулах хэрэгтэй. Сургалтыг орон нутгийн хөдөө аж ахуй, бэлчээр хариуцсан мэргэжилтэн эсвэл мэргэжлийн зөвлөхүүдээр дамжуулан зохион байгуулж болно. Бэлчээрийн ашиглалтанд оролцогч талууд мэдлэг ойлголттой болсны дараа төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг бүх талуудын төлөөлөл оролцуулан байгуулах нь тэдгээрийн оролцоог хангах гол арга зам болно.

Ажлын хэсэг нь олон нийтийн оролцооны аргад тулгуурлан бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөөг баг тус бүр дээр гаргаж, тэдгээрийг нэгтгэн боловсруулсны дараа сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй. Бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулахад хамтран ажиллах бүтцийг тодорхойлох шаардлага гарч ирнэ. Хамтран ажиллах бүтцийг сумын удирдлага, багийн ИНХ, малчид, малчдын бүлэг, хоршоо, иргэний нийгмийн байгууллагаас төлөөлөл оролцуулж хамтын удирдлагын хороо эсвэл төрийн бүс байгууллага хэлбэрээр байгуулж болох юм. Хэрэв тухайн суманд Олон талт зөвлөл /дараагийн сэдвүүдэд дэлгэрүүлэн үзнэ/ байгуулагдсан тохиолдолд бэлчээрийн хамтын менежментийг энэ зөвлөл хариуцаж болно. Магадгүй сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглан малчдын бүлэг, хоршоод бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж болох юм. Бэлчээрийн хамтын менежментийг амжилттай хэрэгжүүлж буй аймаг, сум, малчдын бүлэг, хоршоод цөөнгүй бий.

Шигтгээ: Архангай аймгийн Их Тамир сумын туршлагаас

Тус сум нь бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор 2005 онд сумын нийт малчдын хүрээнд хамтын бэлчээрийн менежментийн талаар ойлголт өгөх сургалтыг зохион байгуулжээ. Сургалтанд оролцогчдоос ажлын хэсэг гаргаж, оролцооны аргад тулгуурлан бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөөг баг тус бүр дээр боловсруулан, нэгтгэв. Үүний дараа сумын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, сумын ИТХ-аар батлан хэрэгжүүлэв. Бэлчээрийн хамтын удирдлагын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг зохион байгуулах бүтэц шаардлагатай болсон. Энэхүү бүтцийг “Аривжин сайжрах” нэртэй төрийн бүс байгууллагын хэлбэрээр байгуулжээ.

Сумын хэмжээнд хамтын удирдлагын төлөвлөгөөний дагуу бэлчээрийн сэлгээ хийх, өнжөөх, амрахад тулгарсан гол бэрхшээл нь хүн малын усан хангамжийн асуудал байлаа.

Иймд малчид хамтран шаардлагатай газруудад гар худаг 6, энгийн үүрхайн худаг 3-ыг гаргасан нь ашиглагдахгүй байсан их хэмжээний бэлчээрийг ашиглах, 41 мянга гаруй толгой мал, 36 малчин өрхийг усаар хангах боломжийг бүрдүүлсэн.

Бэлчээрийн хамтын удирдлагын төлөвлөгөөний дагуу сум, багийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар зун намрын бэлчээрийн сэлгээг хэлэлцүүлэн баталж ажилласны үр дүнд нийт малчин өрхийн 70 хувь нь отор нүүдэл, бэлчээрийг сэлгэн ашиглаж хэвшсэн байна.

Эх сурвалж: Бэлчээрийн менежментийн холбоо, www.msrm.mn

2.5 ЭРДЭС БАЯЛАГИЙН НӨӨЦ

Эрдэс баялагийн нөөцийн ашиглалтын онцлогийг дурдвал:

- Эрдэс баялаг нь ганцхан удаа ашиглаад дуусдаг, нөхөн сэргээгдэхгүй нөөц;
- Эрдэс баялгийг ашиглахын тулд ус, хөрс, агаар, ой мод, эрчим хүч зэрэг бусад байгалийн нөөцүүдийг давхар ашигладаг;
- Нөөцийг ашигласнаар тухайн орон нутгийн иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах зэрэг үндсэн эрх хөндөгдөж байдаг.



Сүүлийн 10 гаруй жилд дахин сэргээгддэггүй нөөц болох эрдэс баялаг (алт, нүүрс, төмрийн хүдэр, зэс, цайр, газрын тос, жонш гэх мэт)-ийн ашиглалт нэмэгдэж, уул уурхайн салбар ДНБ-ний 30 хувьд хүрч улс орныхоо хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр оруулж байна. Эрдэс баялагын олборлох салбарын энэхүү өсөлт нь байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг ихэсгэж, түүнээс улбаалан эрүүл мэнд, нийгмийн асуудлууд тулгарах болов. Байгаль орчны нөлөөлөл нь тухайн газар нутагт ургамал, амьтан устаж, дайжих, цаг уур болон хөрс, агаар, усны чанарт өөрчлөлт гарч экологийн тэнцвэр алдагдаж байна.

Бодитойгоор нүүрлэж буй энэхүү сөрөг үр дагаврыг бууруулах, нөөцийн хариуцлагатай ашиглалтыг бий болгох, төлөвшүүлэх нь өнөөдөр, маргааш болон ойрын ирээдүйн хамгийн хүнд асуудал юм. Хүнд асуудал гэж тодорхойлсон нь эрдэс баялагийн нөөц хязгаарлагдмал бөгөөд энэхүү хязгаарлагдмал нөөцийг ашиглах үйл явц нь байгаль, экологи, нийгэмд зайлшгүй сөрөг үр дагаврыг дагуулж байдагтай шууд холбоотой.

Шигтгээ: Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль цаазын бичиг...

“Аливаа алт, мөнгөний зэрэг орд, элс гаргах газрыг харьяа засаг, түшмэл хариуцах, хэрэв эдгээр баялагийг монгол хүмүүс болон гадаадын хүн, мөн хоорондоо нийлж хулгайлан ашиглавал байцаан шийтгэх, хэрэв засаг түшмэл нь мэдэлгүй алдаж, эндсэн байвал засаг түшмэлийг 9 малаар торгох, пүнлүүг үрт богино хугацаагаар хасах, 100 хүртэлх ташуур занчих, орд гарах уулын эзэн цаазыг зөрчин ардыг удирдан орд ухаваас түүнийг 35 өдөр дөнгөлж 90 ташуур занчих” гэж заажээ.

Эх сурвалж: Байгаль орчны нэвтэрхий толь.

2.5.1 ЭРДЭС БАЯЛАГИЙН ХАРИУЦЛАГАГҮЙ АШИГЛАЛТЫН ҮР ДАГАВАР

Эрдэс баялагийн ашиглалтын төрөл, хэлбэрээс хамаарч хүний эрүүл мэнд, амьдрах орчин болон байгаль орчинд шууд болон шууд бус буюу дам хэлбэрээр сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

Шууд ба шууд бус нөлөөллүүдийг үйл ажиллагааны шинж чанар буюу давтамж, хэмжээ, үргэлжлэх хугацаа зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан тодорхойлдог. Тэгээд ч сөрөг нөлөөллүүд нь агаарын чанар, дуу чимээ, хөрсөн бүрхэвч түүний элэгдэл, гадаргын ус болон гүний усны нөөцийн хомсдол, ургамлын нөмрөгийн өөрчлөлт, амьтдын амьдрах орчин, өнгөн хөрс хуулалт, соёлын өв, дурсгалт газрууд, хүлэмжийн хийн ялгаралт зэргээр илрэн гардаг. Эрдэс баялаг ашиглахтай холбоотой гарч ирдэг нөлөөллүүдийг газрын үржил шим, агаарын чанар, усны нөөцийн хүрээнд товч авч үзье.

Газрын үржил шим

Уул уурхайн үйлдвэрлэл нь газрын өнгөн хөрсийг хуулж, ашигт малтмалыг олборлохдоо байгалийн тогтоц, орчныг өөрчилж сүйтгэдэг. Газрын хэлбэр дүрсийг харагдах байдлаар нь төдийгүй бүтцээр нь өөрчилнө. Уул уурхайн компаниуд олборлолт хийх явцдаа уулын орой хэсгийг тэр чигээр нь авах тохиолдол байдаг. Ихэнх уул уурхайн талбай нь олон зуун метр гүн мөн олон арван км өргөн байх нь түгээмэл. Энэ байдал нь ургамалжилт, хөрс болон үндсэн чулуулагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэж байгалийн тогтоцыг илүү тогтворгүй, эмзэг болгож элэгдлийг нэмэгдүүлдэг. Элэгдэл нэмэгдсэнээр:

- Гадаргын усны урсгал болон урсац өөрчлөгдөх;
- Үнэт, үржил шим бүхий өнгөн хөрсний алдагдал;
- Газрын болон усны орчны эвдрэл, гэмтэл;
- Налуугийн тогтворгүй байдал бий болох гэх мэт нөлөөллүүд гардаг.

Зарим тохиолдолд уул уурхайтай холбоотойгоор чулуулаг болон хөрсний давхарга аажмаар доошилж суулт өгдөг. Үүний улмаас гол горхины байгалийн урсгал өөрчлөгдөж хүн, мал амьтан төдийгүй дэд бүтцэд аюул учруулдаг байна.

Агаарын чанар

Агаарын чанар үзэгдэх орчин, эрүүл мэнд болон аюулгүй байдалд нөлөө үзүүлдэг учраас экосистемийн маш чухал бүрэлдэхүүн хэсэг. Уул уурхайн үйл ажиллагаа нь чулуужсан түлш шатаах, ухалт болон өрөмдлөг хийх улмаар барилга байгууламж барих зэргээс агаарын чанарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг. Уурхайн эргэн тойрны агаарын чанарт тоос шороо болон дотоод шаталтын хөдөлгүүрүүдээс гарах утаа тортог ихээр нөлөөлнө. Хүдэр бутлах, тээвэрлэлт, салхинд хийссэн болон ил задгай хог хаягдлын овоолго мөн л тоос шороо ялгаруулалтыг нэмэгдүүлдэг. Ийм төрлийн тоос шороо нь их хэмжээний хорт бодис агуулах магадлал өндөртэй бөгөөд хүрээлэн буй орчинд агаараар дамжин тархдаг.

Усны нөөц

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ус гол хүчин зүйлийн нэг. Ил уурхай, хаягдал чулуулгын овоолго, боловсруулах үйлдвэр болон уул уурхайн дэд бүтэц нь гол горхины хэлбэр, загварыг өөрчлөхөд хүргэдэг. Энэ өөрчлөлт нь уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй хэсгээс үрсгал дагуух экосистем болон орон нутгийн иргэдэд хүрэх усан хангамжийн дутагдалд оруулах аюулыг дагуулдаг. Мөн уурхайн ашиглалтын болон боловсруулах үйл ажиллагаанд түлш, тос тосолгооны материал, цэвэрлэгээний бодис, тэсрэх бодис, уусгагч болон будаг зэрэг олон янзын химийн аюултай хортой бодисыг ашигладаг. Ашиглахын тулд түүнийг тээвэрлэх, хадгалах асуудал гарч ирнэ. Хэрвээ тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын үед алдаа гарах тохиолдолд гадаргын болон гүний усны нөөцийг бохирдуулах нөлөөлөл үзүүлдэг байна. Эдгээр нөлөөллийг тооцож, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай.

2.5.2. ЭРДЭС БАЯЛАГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ АШИГЛАЛТ

Эрдэс баялагийн хариуцлагатай ашиглалтыг төлөвшүүлэхэд анхаарал байнга хандуулах хэрэгцээ шаардлага бодит амьдралаас урган гарч байгаа билээ.

Монгол улсын Их хурлаас “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ыг 2014 оны 1 сард батлан гаргасан. Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ гэж заажээ. Энэ бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчинг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино. Мөн бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар заасан байна.

Уул уурхайн компаниудын хариуцлагатай байдлыг төр захиргааны болон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс үнэлэхдээ “Байгаль орчинд хариуцлагатай байх”, “Нийгэмд хариуцлагатай байх” гэсэн үндсэн хоёр хүчин зүйлийг авч үздэг. Тиймээс “АШИГЛАЛТ+ХАРИУЦЛАГА” гэсэн ойлголтуудыг салгаж


болохгүй. Хариуцлагатай байна гэдэг ашиглалтын бүхий л үйл ажиллагаа Монгол улсын хуулийн хүрээнд ил тод явагдахаас эхэлнэ.

Байгаль орчинд хариуцлагатай байх

Тухайн компани нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, бохирдол ба хаягдлыг хамгийн бага түвшинд байлгах технологи (үүнийг байгаль орчинд ээлтэй технологи ч гэж нэрлэдэг) ашиглахаас эхлэн байгаль орчинд учруулсан хохирлоо бууруулахын тулд ашигласан газартаа техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх замаар ургамал тариалах, цаашид ашиглах боломжтой болгон хүлээлгэж өгөх үүргийг хуулийн дагуу хүлээдэг.

Мөн түүнчлэн тухайн ордын нөөц ашиглах техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, уурхайн гэнэтийн зогсолт болон хаалтын төлөвлөгөө түүнчлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнүүд бүрэн хэрэгжих гэсэн өргөн ойлголтуудыг багтаана. Өөрөөр хэлбэл, уул уурхайн компани нь удирдлагын тогтолцоондоо байгаль орчныг хамгаалах, мониторинг хариуцсан бүтэцтэй байж энэ нь байгалийн нөөц ашиглалтад мониторинг, үнэлгээ хийж эрсдлээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдлийг бууруулах, арилгах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан ажиллах учиртай.

Зураг 2. Уурхайн ашигласан усыг цэвэршүүлж дахин ашиглах



Нийгэмд хариуцлагатай байх

Байгалийн аливаа нөөцийг ашиглахын тулд тухайн орон нутгийн үүгүүл иргэдийн эрхийг хүндэтгэх замаар орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө үр дүнтэй хамтран ажиллах ёстой гэсэн ойлголт юм. Орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхэд орон нутгийн удирдлага голлох үүрэг хүлээнэ. Тухайлбал, нутгийн удирдлагын зүгээс уул уурхайн компаниудтай

хамтран иргэдийнхээ ая тухтай амьдрах орчин, тогтвортой орлого, ажлын байртай байх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санаачлага гарган, улмаар үйл ажиллагаандаа талуудын оролцоог хангах шаардлагатай. Байгалийн нөөц ашиглалтын явцад байгаль орчны болон нийгмийн хариуцлагыг хангахад талуудыг оролцуулах явдал чухал гэж үздэг.

Эрдэс баялагийн хариуцлагатай ашиглалтыг бий болгох гол гарц нь хариуцлагатай уул уурхайг (ХУУ) хөгжүүлэх явдал. ХУУ-н талаар олон тодорхойлолт байдаг бөгөөд эдгээрээс Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхайн санаачлага төрийн бус байгууллага (ТХТХУУС ТББ)-с гаргасан тодорхойлолтыг танилцуулъя.

“Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль сахиx ёсыг дээдэлсэн, Монгол улсад байнгын ашиг оруулж байх эрдэс нөөцийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай” гэнэ. ХУУ-н талаарх ойлголтыг илүү тодруулах зорилгоор тус төрийн бус байгууллага доорх 8 зарчмыг томъёолжээ. Үүнд: а) олон талын оролцоог хангах, б) ил тод нээлттэй байх, в) хуулийг сахин дээдлэх, г) байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх, д) ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах, е) үр өгөөжтэй байх, ё) хүмүүнлэг ёс зүйтэй байх з) дэвшилтэд технологид суурилсан байх гэсэн зарчмууд юм. Эдгээр зарчмууд нь бие биенээсээ хамааралтай, нэг зарчим хангагдвал нөгөө зарчим нь мөн адил хангагдана гэсэн үг. Тухайлбал, олон талын оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлснээр ил тод байдал бий болдог. Ил тод байдал бий болсноор итгэлцэл бэхжих учиртай.


Зураг 3. Иргэдийн санал



Оролцогч талууд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор эргээд тухайн уурхайд ашигтай бөгөөд орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулна. Энэ зарчмаар ажиллан амжилтанд хүрсэн туршлага улс орнуудад бий.

Уул уурхай өндөр хөгжсөн Канад, Австрали улсуудын туршлагаас харахад аливаа байгалийн нөөцийг ашиглахын тулд нутгийн уугуул иргэд, компани, орон нутгийн захиргааны байгууллагууд олон талт хамтын ажиллагааны гэрээ байгуулах замаар талуудын оролцоог хангадаг ажээ. Талуудын оролцооны эрх үүрэг, хариуцлагуудыг уг гэрээнд маш тодорхой зааж өгдгөөрөө тогтвортой хөгжилд чиглэсэн үр ашигтай хамтын ажиллагааг бий болгожээ.

Зураг 4. Уул уурхайн одоо ба ирээдүй



Шигтгээ: Уул уурхайн үйлдвэрлэлийн нийгмийн хариуцлага

2011 оны 12 дугаар сард “Уул уурхайн үйлдвэрлэлийн нийгмийн хариуцлага” сэдэвт зөвлөгөөнийг Уул уурхайн яамтай хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөнд 150 гаруй хүн оролцож, уул уурхайн компани, орон нутгийн төр захиргааны байгууллагын төлөөлөгчид оролцсон. Зөвлөгөөнөөр оролцогчид Уул уурхайн нийгмийн хариуцлагыг үндсэн 3 хүрээнд гаргав. Үүнд:

- Байгаль орчны нөхөн сэргээлт;
- Усны хэмнэлттэй, дахин ашиглах компаний бодлого;
- Орон нутгийн иргэд, төр захиргааны байгууллагатай харилцаа тогтоох.

Түүнчлэн Уул уурхайн нийгмийн хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон. “Олон талт тулгуурласан, байгальд ээлтэй үйл ажиллагааны зарчмаар ирээдүйн өмнө хүлээх хариуцлагаа үхамсарласан, орон нутгийн хөгжилд анхаарал хандуулсан, хүүлийг дээдлэн ажиллаж буй байдлыг хэлнэ”.

Эх сурвалж: “Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд уул уурхайн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх нь” П.Болормаа. АНУ-ын Азийн сан. Байгаль Орчны хөтөлбөрийн захирал.



БҮЛЭГ 3



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ
ХАНГАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦОО

3.1. ТАЛУУДЫН ОРОЛЦОО ГЭЖ ЮУ ВЭ?

Талуудын оролцоо гэдэг нь байгалийн нөөц ашиглалтад оролцогч талуудын тогтвортой хөгжилд чиглэсэн, хамтын ажиллагааны, урт хугацааны үргэлжилсэн үйл явц юм. Тодорхойлолтод туссан ухагдахууныг тодруулж үзье.

Тогтвортой хөгжил гэдэг нь “Байгаль орчин, нийгэм, эдийн засаг” гэсэн гурван асуудлыг нягт хамаарал шүтэлцээтэй авч үзэж, байгалийн хишиг, нөөц, баялаг өгөөжийг зүй зохистой ашиглан, өнөө болон хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийн төлөө нийгмийг бүтээн байгуулах” гэсэн утгыг илэрхийлдэг. Хамтын ажиллагаа гэсэн ойлголт нь талууд зөвхөн мэдээллээ солилцоод өнгөрөх бус “хамтрагч”, “түншлэгч” гэсэн байр суурин дээр ажиллана. Өөрөөр хэлбэл, эрх мэдэл, нөөцийг үр ашигтай ашиглах хэмжээнд талууд бие биенээ хүлээн зөвшөөрөхийг хэлнэ. **Урт хугацааны үргэлжилсэн үйл явц** нь байгалийн нөөцийн хайгуулын үеэс эхлэн ашиглаж дуусах хүртэлх хугацаанд оролцоо тасралтгүй явагдаж байхыг хэлдэг.

Зураг 5. Талуудын уулзалт



Амьдрал дээр оролцоо нь талуудаас их хүчин чармайлт, хөрөнгө хүч, цаг хугацаа, олон удаагийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг шаарддаг. Иймд сум орондоо үр дүнтэй оролцоог хангахын тулд дараах арга замуудаар тасралтгүй ажиллахыг санал болгож байна.

Мэдээлэл солилцох уулзалтууд

Талуудын оролцооны амин зүрх нь талууд мэдээллээ бусад оролцогч талуудад үнэн зөв гаргаж өгөх явдал юм. Иймд оролцоо нь мэдээлэл солилцох уулзалтуудаас эхлэх ёстой. Мэдээлэл солилцоноор талууд дараах үр дүнд хүрдэг. Үүнд

- Талууд бие биенээ таньж мэдэх, ямар санаа бодолтой, ашиг сонирхолтой байгааг тогтоох;
- Ямар нөхцөл байдлууд үүсээд байгаа, түүнийг урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах арга замуудыг тодорхойлох;
- Нэгдсэн зорилго тодорхойлох;
- Дараагийн үүлзалтүүдын товыг тогтоож, хэлэлцэх асуудлыг жагсаах

Зөвлөлдөх, хэлэлцүүлэг өрнүүлэх

Аливаа асуудлын талаар тооцоо судалгаанд үндэслэн талууд зөвлөгөөн хэлэлцүүлэг өрнүүлж болно. Уг асуудалтай холбогдолтой нарийн мэргэжлийн хүмүүс, байгууллага, эрх бүхий талуудыг оролцуулах нь элбэг. Өөрөөр хэлбэл, уул уурхайн компани, иргэдийн төлөөлөл болон төрийн байгууллагын талаас гадна холбогдох бусад талуудтай өргөтгөсөн байдлаар хэлэлцүүлгийг явуулж, тухайн асуудлыг шийдэх хувилбаруудыг тодорхойлох, харилцан зөвлөлдөх хэрэгтэй.

Шигтгээ: МУ-н Хүний хөгжлийн илтгэл 2011-н бодлогын зөвлөмжөөс...

“Аливаа шийдвэр гаргахад холбогдох байгууллага, хувь хүмүүсийг татан оролцуулах нь хүний тогтвортой хөгжлийг хангахад маш чухал. Энэ нь олон нийтийн болоод хэсэг бүлгийн үйл хэрэгт чөлөөтэй хамтран оролцох, хувь хүний үнэ цэнийг товойлгох, үзэл бодлоо нээлттэй илэрхийлэх зэргийг багтаасан “талуудын эрх чөлөө”-ний тухай ойлголттой дүйж байгаа юм.”

“Аймаг, сумдын түвшинд “байгаль орчны асуудлаарх иргэдийн зөвлөл”-ийг байгуулах. Эдгээр зөвлөлөөс орон нутгийн хүний хөгжил болон байгаль орчны холбогдох асуудлаар илтгэл тайлан тогтмол гаргахыг дэмжих”. 95-р хуудас

Хамтран ажиллах

Олон улсын практикт оролцоог хамтын ажиллагааны түвшинд хүргэх баталгаа нь оролцогч талуудаас эрх, үүргээ тодорхойлсон хамтын ажиллагааны гэрээ байгуулах нь бий. Түүнчлэн оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн олон талт зөвлөл байгуулагдаж, хэлэлцэн тохирсон ажлын үр дүн, хяналт мониторинг ба гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах ажлуудыг хэрэгжүүлдэг.

Оролцогч талуудын талаар авч үзье. Байгалийн нөөц ашиглалтад оролцогчдыг гол оролцогч талууд ба бусад оролцогч талууд гэж ангилж болно. Тухайн нэг талын үйл ажиллагаа нь бусад талуудын хууль ёсны ашиг сонирхлыг шүүд хөндөж байгаа тохиолдолд тэдгээрийг гол оролцогч талууд гэж үзнэ. Энэ бүлэгт байгалийн нөөц ашиглалтын гол оролцогч талуудын талаар авч үзэх болно.

Гол оролцогч талууд	Бусад оролцогч талууд
<ul style="list-style-type: none"> • Нутгийн засаг захиргаа / сумын ИТХ, ЗДТГ/ • Нутгийн иргэдийн төлөөлөл • Тухайн орон нутагт байгалийн нөөц ашиглаж буй компани 	<ul style="list-style-type: none"> • Төрийн чиг үүрэг бүхий байгууллагууд • Төрийн бус байгууллагууд • Бичил уурхай эрхлэгчид • Уул уурхайн үйл ажиллагаанд туслан гүйцэтгэгч эсвэл бэлтгэн нийлүүлэгч бизнесийн байгууллагууд

Нутгийн засаг захиргаа

Орон нутгийн засаг захиргаа байгалийн нөөцийг ашиглахтай холбоотой хууль, дүрэм, журам болон бусад стандартыг мөрдүүлж, биелэлтийг хангах эрх үүргийг хэрэгжүүлдэг гол оролцогч тал юм. Монгол улсын холбогдох хуулиудад нутгийн засаг захиргааны эрх, үүрэг, хариуцлагуудыг тодорхой зааж өгсөн байдаг. Тэдгээрт *Аливаа асуудлыг иргэдийнхээ нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. /Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 8 дугаар зүйл/. Нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв батлах, биелэлтэд хяналт тавих. /Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 17 дугаар зүйл/ Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн ашиглалтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй. /Ашигт малтмалын тухай хууль, 39 дүгээр зүйл/ гэжээ.*

Нутгийн иргэдийн төлөөлөл

Байгалийн нөөц ашиглалтын нөлөөнд өртөж эрх ашиг нь шууд хөндөгдөж байгаа нутгийн уугуул иргэд нь оролцооны нэг гол тал болдог. Иргэд оролцох эрх зүйн үндсийг Монгол улсын холбогдох хуулиудад тодорхой зааж өгсөн байдаг.

Тухайлбал: Монгол улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад нөөц гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. */Монгол улсын үндсэн хууль, 6 дугаар зүйл/.* Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй. */Монгол улсын үндсэн хууль, 16 дугаар зүйл/*

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа

сонгон ажиллуулж болно. /*Ашигт малтмалын тухай хууль, 42 дүгээр зүйл*/ гэж тус тус заажээ.

Иргэд нь өндөр настан, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, ажиллагсад зэрэг нийгмийн олон бүлгүүдийн төлөөллөөс бүрдэнэ. Эдгээр бүлгүүд өөр өөрийн гэсэн хэрэгцээ шаардлага, асуудалтай. Тухайлбал малчдын хувьд малын бэлчээр, ус болоод өвөлжөө, хаваржааны газар нь лицензийн талбайд орох, сумын төвийн иргэдийн ундны ус бохирдох гэх мэтээр иргэдийн эрүүл, аюулгүй аж төрөх нөхцлийг уул уурхайн үйлдвэрлэл хязгаарлаж байдаг.

Иймд байгалийн нөөц ашиглалтын талаар иргэдийн өөр өөр байр суурь, ашиг сонирхолыг ерөнхийд нь хүлээн зөвшөөрч, хооронд нь үялдуулж, нийтлэг сонирхлыг тодорхойлох хэрэгтэй. Ингээд ерөнхий нийтлэг сонирхлуудыг эрэмбэлж, нэн тэргүүний нийтлэг зорилгыг гаргаж ирнэ. Амьдрал дээр нийгмийн төлөөллийн дүү хоолой, оролцоог хангахын тулд иргэд дундаасаа албан бус зөвлөл эсвэл албан ёсны төрийн бус байгууллага байгуулан нэг тал болон оролцох нь бий.

Шигтгээ: Нутгийн сайн дурын зөвлөлийн талаар

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж буй үндэсний томоохон уул уурхайн компани болох “Энержи ресурс” ХХК нь 2010 онд орон нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллах, малчид, иргэдийн санал санаачлага, зөвлөмж үзэл бодлыг компаний бодлого, үйл ажиллагаанд тусгах, орон нутгийн хөгжлийг дэмжих үйлст хамтран ажиллах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад нутгийн сайн дурын зөвлөлийг байгуулав. Зөвлөлийн бүрэлдэхүүнд сумын малчид, иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, орон нутгийн ТББ-үүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг хамруулсан болно. Зөвлөлийн үүлзалт, хэлэлцүүлэг сар бүр зохион байгуулагдаж, зөвлөмжийг “Энержи Ресурс” ХХК-ийн удирдлагад хүргүүлдэг.

/эх сурвалж: www.energyresources.mn

Байгалийн нөөц ашиглаж буй компани

Компани нь ашиг олох зорилгоор тухайн орон нутагт байгалийн нөөцийн хайгуул ба ашиглалт хийж буй гол оролцогч тал юм. Компани нь оролцоонд чухал хариуцлагатай тал байх эрх зүйн үндсийг Монгол улсын үндсэн хууль, Байгаль хамгаалах хууль, Ашигт малтмалын тухай хуулиудад заасан байдаг. Тэдгээрээс дурдвал Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх

асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. /*Ашигт малтмалын тухайн хууль, 42.1*/. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо, хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 улиралд багтаан нийтэд мэдээлнэ. /*Ашигт малтмалын тухайн хууль, 48.10*/ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42 .1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно /*Ашигт малтмалын тухайн хууль, 42.2* / гэж заасан.

Шигтгээ: Ашиглалт явуулсан газраа харлуулж биш ногооруулж байна...

Булган аймгийн Сайхан сумын нутаг дахь Эрээний нүүрсний ордын 35 га талбайг “Илчит металл” ХХК 2003 оноос ил уурхайн аргаар ашиглаж эхэлсэн. Улмаар 2008 оны тавдугаар сард АНУ-ын хөрөнгө оруулалттай “Пибоди Винсвей ресорсез” ХХК Эрээний нүүрсний уурхайн ашиглалтын талбайгаас хэсэгчлэн шилжүүлэн авч олборлолтын үйл ажиллагаа явуулсан байна. Тус компани байгуулагдсаны дараа Эрээний нүүрсний уурхайг түр хааж, нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн бөгөөд уурхайн ажил эхлэхээс эхлэн бүхий л хугацаанд нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, санаа бодлоо хуваалцжээ. Сум, орон нутгийн удирдлагуудтай ярилцаж, нутгийн иргэдтэй уулзалт хийхэд тэд бэлчээрийн талбай болгон ашиглах санал тавьсны дагуу 15 га газарт техникийн, 18 га газарт 12 төрлийн өвсний үр суулган ногоо үргүүлж, хөрсийг нөхөн сэргээх биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Нөхөн сэргээлт хийсэн газрыг гурван жилийн хугацаанд хашиж мал оруулахгүй. Энэ хугацаанд малчид хадлан авах хэмжээний өвс, ургамал ургачихна гэсэн хүлээлттэй байгаа юм. Тэр болтол сар бүр байгаль орчны мониторингийн судалгаа хийнэ. Судалгаагаар ус, хөрс, цэвдэг үүсэх магадлал хэр байна гэдэгт тооцоо судалгаа хийхээр төлөвлөсөн. Хадлан бэлчээрийн талбай бий болгохын зэрэгцээ хөрсний усыг ашиглан үндны усны худаг, мал услах цөөрөм байгуулсан. Цаашид тэгш газарт нь хүнсний ногоо тарих, хадлангийн талбай болгон ашиглах боломжтой аж.

Эх сурвалж: “Өнөөдөр” сонин j;l2010/09/20 С.Батзаяа http://www.mining.mn/NewsDetails_3877.aspx

3.1.1. Оролцогч талуудын ашиг сонирхлууд

Талууд оролцоонд олон ашиг сонирхлын үүднээс ханддаг. Оролцооны чухал үүргийн нэг бол талуудын ашиг сонирхлыг эрэмбэлэх, нийтлэг ашиг сонирхлын үүлварыг гаргаж, талуудын зөвшилцөлд хүрсэн хамтын гэрээ, санамж бичиг байгуулахад оршино.

Зураг 6. Талуудын ашиг сонирхол



Доорхи хүснэгтэд талуудын ашиг сонирхлын энгийн жишээнүүдийг дурьдлаа.

Иргэд, иргэдийн бүлэг

- Уламжлалт мал аж ахуй, уугуул нутгаа унаган төрхөөр нь хадгалах, өвлүүлэхэд;
- Тогтвортой ажлын байр, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг авах;
- Сумын тогтвортой хөгжил, жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд дэмжлэг авах;
- Эрүүл, аюулгүй орчинд аж төрөх.

Нутгийн захиргаа

- Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийнхээ аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх;
- Хуулийн хэрэгжилтийг хангуулах, байгаль орчин хүний эрхийн зөрчил гарахаас сэргийлэх;
- Ядуурлыг бууруулах, тогтвортой ажлын байрыг бий болгох.

Уул уурхайн компани

- Өндөр ашигтай уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх;
- Бизнесийн нэр хүндээ өсгөх;
- Бага эрсдэл гаргах.

3.1.2. Оролцооны үед тулгардаг бэрхшээлүүд

Олон хүчин зүйлээс үүдэн талуудын дунд зөрчилдөөн бий болдог. Зөрчилдөөн бүхэн муу байдаггүй бөгөөд зарим үед ахиц, дэвшлийг авчрах нь бий. Онолын үүднээс талуудын зөрчилдөөний үед хэлэлцээр хийх, зуучлах, арбитражи болон хуулийн аргуудаар зохицуулдаг. Эдгээр аргууд нь давуу болон сул талуудтай. Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтад талуудын оролцоог хангах үйл явцад түгээмэл тохиолддог бэрхшээлүүдийн талаар товч авч үзье.

Мэдээллийн зөрүүтэй байдал

Уул уурхайн төсөл эхлэх үеэс иргэд, иргэдийн бүлгүүдэд мэдээлэл зөрүүтэй хүрдгээс бодит бус хүлээлтүүд бий болдог. Үүнээс үүдэлтэй талууд хоорондын зөрчилдөөн үүснэ. Иймд зөрчилдөөнийг шийдвэрлэхийн тулд талууд үнэн зөв, бодит мэдээллээ солилцож байх, ойлголцлоо ижил түвшинд хүргэх хэрэгтэй юм.

Зураг 7. Уул уурхай дагасан хүлээлт



Иргэд, иргэдийн бүлэг доторх зөрчилдөөн

Иргэдийн бүлэг нь дотроо олон төлөөллөөс /ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучууд, ажилгүйчүүд гэх мэт/ бүрдсэн байдаг. Тэдний хүсч буй зүйлүүд өөр өөр байдаг бөгөөд зорилго, үнэлэмж, хүлээлт нь харилцан адилгүй байдаг. Ийм шалтгаанаар дотроо зөрчилдөөн гарах тохиолдол байдаг ба иргэдийн бүлэг эхлээд дотроо энэ асуудлаа хэлэлцэн шийдэж нийтлэг зорилтуудаа тодорхойлох нь зүйтэй. Эхний ээлжинд нийтлэг асуудлаа шийдвэрлэх, дараа нь асуудлуудаа эрэмбэлэх шаардлага ч гарч ирж болно.

Талууд хоорондын зөрчилдөөн

Оролцооны явцад компани болон иргэдийн бүлэг хооронд эсвэл компани болон иргэдийн бүлгийн зарим гишүүдийн хооронд үзэл бодол нийлэхгүй байж болно. Энэ бэрхшээлийг даван туулахад харилцан үр ашигтай байх, бүтээлч ил тод харилцаа чухал үүрэгтэй. Жишээ нь: иргэдийн бүлэг буюу тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид компанид хүрэлцэн ирж, үйл ажиллагаа, бизнесийн төлөвлөгөөтэй танилцах, компани иргэдийн бүлэгт өөрсдийн санаа бодол, төлөвлөгөөгөө үнэн зөв, ил тод танилцуулах нь эхний чухал алхам болно. Мэдээж компани өөрөө иргэдийн бүлгийн гишүүдийг хүндэтгэж харьцах мөн ахмадууд, эмэгтэйчүүд, залуучууд болон цөөнхи иргэдийг сонсох зэрэг нь зөрчилдөөн, үл ойлголцлыг багасгаж цаашдын хэлэлцээрүүд амжилттай болох сайн талтай.

Оролцогч талуудын чадвар

Оролцоо нь талуудаас олон талын мэдлэг, үр чадварыг шаардана. Тухайлбал, талуудаас харилцааны үр чадвар, амьдралын нарийн арга ухаан, хууль эрх зүйн үндсэн ойлголт, үүл уурхайн мэдлэг, түршлага зэрэг нь оролцоог амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй. Аль нэг оролцогч талын төлөөллийн харилцааны үр чадвараас шалтгаалан оролцоо мухардалд хүрэх, нөгөө оролцогч талдаа давуу боломжийг олгох зэргээр зөрчилдөөн үүсч болзошгүй.

Шигтгээ: Бодит байдал дээр түгээмэл гарч буй зөрчлүүд....

1. Уул уурхайн салбарт лицензгүйгээр олборлолт явуулах, нөхөн сэргээлт дутуу хийх, ус ашиглалтын журмыг зөрчих, байгаль орчинг химийн бодисоор хордуулах зэрэг зөрчлүүд нэлээд гардаг. Мөн лиценз эзэмшигчид хуульд заасан гүйцэтгэлийн тайлан, байгаль орчны нөхөн сэргээлтийн тайлан, аюулгүй ажиллагааны тайлан зэргийг гаргаж өгдөггүй гэх мэт зөрчлүүд байсаар байна.
2. Уул уурхайн компани орон нутгийн иргэдийг ажлаар хангана гэж ажилд авчихаад хэсэг хугацааны дараа ажлын шаардлага хангах үр чадваргүй, тэнцэхгүй гэх мэт шалтгаанаар ажлаас нь гэнэт халдаг. Тухайлбал: 2009 оны 6 сард “Бороо гоулд” ХХК-д ийм байдал гарсан.
3. Уул уурхайн компани өөрийн эзэмшлийн лицензээ бусдад зарах, эсвэл компанийхаа нэрийг өөрчлөн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, өөрсдийн хариуцлага, амалсан амлалт, гэрээгээр хүлээсэн үүргээсээ зайлсхийж орон нутгийн иргэд, удирдлагын итгэлийг хөсөрдүүлэх асуудал гарсаар байна.

3.2. БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ АШИГЛАЛТАД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ БИЙ БОЛГОХ

Талуудын оролцоог амьдралд хэрэгжүүлэхийн тулд талуудын уулзалт, хэлэлцүүлгүүдээс ажил эхэлнэ. Анхны уулзалт, хэлэлцүүлгийг аль нэг тал нь санаачлан явуулах хэрэгтэй болдог.

Санаачлага гаргах боломжтой талууд	Үндэслэл
Орон нутгийн ИТХ, Засаг дарга	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8-р зүйлд “Аливаа асуудлыг иргэдийнхээ нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг үндэслэн Иргэдийн хурал санаачлагыг гаргаж болно.
Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Анхны уулзалт, хэлэлцүүлгийг тусгай зөвшөөрөл эзэмшигч компани санаачилж болно. Ашигт малтмалын тухай хуулийн 42.2-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно” гэж заасан.
Нутгийн уугуул иргэд, иргэний нийгмийн байгууллага	2007 оны 10 сарын 02-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан Уугуул Иргэдийн Эрхийн Тунхаглалын 10:18:19:27:28:29:32 дугаар зүйлүүдэд “Газар нутаг дээр нь явагдах хөгжлийн төслүүд, газар, байгалийн нөөцийг нь ашиглах аливаа төсөл хөтөлбөрүүдэд тухайн орон нутгийн уугуул иргэд оролцох эрхтэй бөгөөд эдгээр төсөл хөтөлбөрүүд батлагдахаас өмнө урьдчилан мэдээлэл авч, шийдвэр гаргах үйл явцад чөлөөтэй оролцох эрхийг баталгаажуулсан. Ийм төсөл, хөтөлбөрүүдэд уугуул иргэдийн зөвшөөрлийг заавал урьдчилан авч байх үүргийг төр, засагт хүлээлгэсэн. Төр засаг уугуул иргэдийн уламжлал, зан заншил, газар нутгаа эзэмших ашиглах, захиран зарцуулахтай холбоотой уламжлал тогтсон заншил, хандлагыг хүлээн зөвшөөрч, түүнийг хүндэтгэсэн шийдвэр гаргах хараат бус, шударга, ил тод нээлттэй тогтолцоог уугуул иргэдтэй хамтран бий болгож хэрэгжүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Туршлагаас үзэхэд талуудын оролцоог хангахын тулд үндсэн 3 алхмыг хэрэгжүүлэх хэрэгтэй нь нотлогдсон. Үүнд:

- I. Талуудын мэдлэг, ойлголт, хоорондох зөрчлийн талаар судалгаа хийсэн байна. Судалгаагаар талуудын хоорондох зөрчлийн үндсэн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тогтоодог.
- II. Талуудын нэгдсэн ойлголт, зөвшилцөлд хүргэхэд тэдгээрийн мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэй. Иймд тэдгээрийн хооронд уулзалт, семинарыг зохион байгуулж байх.
- III. Талуудын оролцоог хангах механизмыг бий болгох. Энэ механизм нь Олон талт зөвлөл байж болно. Энэхүү зөвлөл нь талуудаас бүрдсэн байх бөгөөд хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Шигтгээ: Аархусын конвенц

Аархусын конвенц нь 1998 оны 6-р сарын 25 –нд Дани улсын Аархус хотод батлагдсан бөгөөд байгаль орчны асуудлаар олон нийт мэдээлэл авах эрх, шийдвэр гаргахад оролцох эрх, эрхээ хамгаалуулахыг тунхагласан конвенц юм. 2001 оны 10-р сарын 30-наас хэрэгжиж эхэлсэн. 2009 оны 7-р сарын байдлаар энэхүү конвенцид Европ болон Төв Азийн 40 улс, Европын холбоо нэгджээ.

Өнөөгийн болон хойч үеийн хүн бүрийн эрүүл энх, сайн сайхан байх орчинд амьдрах эрхийг хамгаалахад хувь нэмрээ оруулахын тулд оролцогч бүр энэ конвенцийн зүйлд заасны дагуу байгаль орчны асуудлаар олон нийтийн мэдээлэл авах эрх, шийдвэр гаргалт дахь олон нийтийн оролцоо болон шүүхээр зөрчигдсөн эрхээ хамгаалахыг нь батлан даах ёстой. Аархусын конвенц нь орон нутгийн, үндэсний болон үндэстэн хоорондын байгаль орчны асуудлаар олон нийтийн мэдээлэл авах, засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоо, шүүхээр зөрчигдсөн эрхээ хамгаалуулах тухай гэсэн гурван гол агуулгатай.

3.2.1. Уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах

Байгалийн нөөц ашиглалтад талуудыг оролцуулах нь их хүчин чармайлт, тодорхой цаг хугацаа шаардана. Иймээс талуудыг оролцуулсан олон удаагийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах хэрэгтэй. Аливаа зүйлийн зөв эхлэл нь цаашдын үр дүнтэй шууд холбоотой тул энд анхны уулзалт, хэлэлцүүлгийг тусгайлан авч үзлээ. Анхны уулзалт хэлэлцүүлгээр дараах зорилтуудад хүрэх нь зүйтэй.

- Талууд бие биенээ таньж мэдэх;
- Харилцан мэдээлэл солилцох;

- Талуудын хамтын ажиллагааны бүтцийг тодорхойлох;
- Дараагийн уулзалтыг товлох.

Уулзалт, хэлэлцүүлгийн эхний алхам бол бэлтгэл ажлыг сайн хангах явдал. Бэлтгэл ажилтай холбоотой дараах зөвлөмжид анхаарна уу.

Уулзалт, хэлэлцүүлэгт талуудаас оролцох төлөөллийг тодорхойлох
Зөв төлөөллийг сонгоход доор дурьдсан асуултуудад хариулах нь Та бүгдийг зөв хүмүүсээр төлөөлөө бүрдүүлэхэд туслах болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Тавигдсан асуудлуудад хэн шууд хариуцлага хүлээх вэ? • Хэн хэн тухайн орон нутаг, иргэд байгууллагуудад нэр нөлөөтэй вэ? • Тухайн асуудлаар шийдвэр гаргах нь хэний эрх ашигт нөлөөлөх вэ? • Хэн ямар ашиг сонирхолтойгоор байгууллагуудыг удирдаж байна вэ? • Өнгөрсөн хугацаанд уг асуудлаар хэн хэн оролцож байсан вэ? гэх мэт
Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах цаг хугацааг тогтоох
<ul style="list-style-type: none"> • Талууд бүгд оролцох боломжтой хугацаа байх, мөн хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацааг нарийн тогтоож баримтлах хэрэгтэй.
Оролцогч талуудад урилга хүргүүлэх
<ul style="list-style-type: none"> • Боломжтой бол санаачлагч тал биечлэн зарыг хүргэх • Хэлэлцүүлэгт бэлтгэх (талууд түс бүр өөрсдийн холбогдох мэдээлэл бэлтгэх)
Хэлэлцэх асуудлын хүрээг тодорхойлох
<ul style="list-style-type: none"> • Нэг удаагийн хэлэлцүүлгээр бүх асуудлыг шийдвэрлэж чадахгүй нь тодорхой. Анхны хэлэлцүүлгээр бие биенээ таньж мэдэх, үнэн зөв мэдээлэл өгөх, хамтын ажиллагааны бүтцээ тодорхойлох нь чухал гэдгийг дээр дурдсан.
Хэлэлцүүлэг явуулах хөтлөгчийг сонгох
<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлгийг хэн хөтлөх талаар талууд өөрсдөө ярилцан шийдэх хэрэгтэй. • Анхны хэлэлцүүлэг болон талуудын байр суурь зөрүүтэй ихээхэн хурцадмал харилцаатай үед хөндлөнгийн мэргэжлийн байгууллага буюу хэлэлцүүлэг хөтлөх чадвартай мэргэжлийн хүнээр хөтлүүлэх нь илүү үр дүнтэй.
Хэлэлцүүлэг зохион байгуулах зардлыг тооцох, санхүүжилтийг шийдвэрлэх
<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлгийн хэмжээ, хүрээнээс хамаараад зохион байгуулалтын тодорхой зардал шаарддаг. Ялангуяа хөндлөнгийн хөтлөгч ажиллуулж байгаа тохиолдолд. Иймд зардлыг нутгийн захиргаа буюу эсвэл компаний талуудаас гаргах нь зөв юм.

3.2.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙГ ТОДОРХОЙЛОХ

Орон нутагт туршилтын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах явцад талуудын оролцоог хангах хамтын ажиллагааны бүтцийг бий болгох ёстой гэж талууд үздэг. Бүтэцтэй холбоотой талуудын гаргасан саналыг танилцуулбал:

- Оролцогч гурван талаас харьцангуй тэнцвэртэй төлөөлөгчдөөс бүрдсэн “Олон Талт Зөвлөл” байх;
- Зөвлөлд сонгогдох иргэдийн төлөөллийн тоо бусад талуудын төлөөлөгчдийн тооноос арай илүү байх /Иргэд нийгмийн олон төлөөллөөс бүрдэж байдаг учир/;
- Зөвлөл удирдлага зохион байгуулалтын тодорхой бүтэц, дотоод журамтай байх;
- Зөвлөлийн бүтэц, гишүүдийн үүрэг хариуцлагыг зөвлөлийн дотоод журмаар зохицуулах;
- Зөвлөлийн нийт гишүүдийн тоо хэтэрхий олон байх шаардлагагүй /15-аас ихгүй байх/;
- Зөвлөлд талууд эрх мэдэл бүхий, шийдвэр гаргах хэмжээний төлөөлөгчдөө сонгох,
- Зөвлөлийн гишүүд орон тооны бус байдлаар ажиллах;

Яагаад заавал бүх талуудыг оролцуулсан олон талт зөвлөл гэж? гэсэн асуулт урган гарч ирж болно. Сумын засаг дарга болон компаний хооронд байгуулсан байгалийн нөөц ашиглалттай холбоотой гэрээнүүд нь нутгийн уугуул иргэдийн эрхийг байнга хөндөж, иргэдэд бодит мэдээлэл очдоггүйгээс шалтгаалан хардалт үл ойлголцол үүсэн улмаар эрх ашгийн зөрчилдөөнийг хурцатгаж байгаа нь хэлэлцүүлгийн явцад харагдаж байсан. Нэг гол тал нь оролцоогүй энэ гэрээ байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг бий болгож чадахгүй гэж үзсэн. Тиймээс талуудын оролцоог хангах гол арга замын нэг нь “Олон Талт Зөвлөл” байгуулах явдал юм.

3.2.3. ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ЗӨВЛӨЛИЙГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

Сум орон нутагтаа талууд үүлзалт, хэлэлцүүлэг хийж байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтын талаар олон талуудаас бүрдсэн зөвлөл /цаашид зөвлөл гэх/ үүсгэн байгуулах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд Зөвлөлийг үүсгэн байгуулах ажлын хэсгийг эхний ээлжинд байгуулахыг зөвлөж байна. Хэрэв боломжтой бол ажлын хэсэг байгуулахгүйгээр анхны хэлэлцүүлгээр “Зөвлөл”-өө үүсгэн байгуулж болно.

Олон талт зөвлөлийн зорилго нь юунд чиглэгдэх вэ?

Тухайн орон нутаг бүр өөрийн гэсэн онцлогтой, олон янзын хүмүүс аж төрж, өөрсдийн соёл уламжлал, үнэт зүйлс бүтээж байдаг. Түүнчлэн байгалийн нөөц ашиглахтай холбоотой үүссэн асуудлууд нь сум орон нутаг бүрт харилцан адилгүй. Иймээс Зөвлөл бүр өөрийн гэсэн зорилгуудыг өмнөө тавихыг үгүйсгэхгүй. Байгалийн нөөц ашиглалттай холбоотой бодит баримт, нөхцөл байдал, туршлагаас үүдэн Зөвлөлийн зорилгыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Байгалийн нөөцийн зүй зохистой, хариуцлагатай ашиглалтыг бий болгох;
- Үр өгөөжийг тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлэх;
- Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах;
- Талуудын идэвхитэй, бүтээлч оролцоог бий болгох.

Зөвлөлийн үндсэн чиг үүргүүд

Зөвлөлийн зүгээс шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг урьдчилан бүх талуудад танилцуулж санал авах, санал солилцох, зөвшилцөх зорилгоор уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж явуулна.

- Тухайн орон нутгийн байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд талуудын идэвхитэй оролцоог бий болгох;
- Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах талаар талуудын нэгдмэл байр суурийг баталгаажуулах;
- Тухайн орон нутгийн байгалийн нөөцийн үр өгөөжийг иргэд шударгаар хүртэх боломжийг бүрдүүлэх;
- Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, хангах.

Зөвлөлийн ажиллах зарчмууд


- Хууль дээдлэх;
- Шударга ёсыг сахих;
- Бие биеэ харилцан хүндэтгэх;
- Харилцан ашигтай байх;
- Талууд ил тод, нээлттэй, эрх тэгш оролцох;
- Олон талт гэрээний үүргээ шударгаар биелүүлэх;

Талуудын төлөөлөл ба тэдгээрийг сонгох.

Талууд зөвлөл дэх төлөөлөө зөв сонгох нь маш чухал бөгөөд төлөөлөл нь тухайн

талынхаа байр суурийг бүрэн илэрхийлж, зөвлөлөөс гарсан шийдвэрийг дамжуулах чадвартай байх хэрэгтэй. Тухайлбал төрийн байгууллагын төлөөллийг албан тушаалаар нь оруулах, малчид иргэдийн төлөөлөлд хууль эрх зүйн мэдлэгтэй хүн оруулах гэх мэт анхаарах зүйл бий.

Олон талт зөвлөлд талуудын төлөөллийн тэнцвэртэй байдлыг хадгалах нь чухал. Үүний тулд зөвлөлийн бүрэлдэхүүн дараах талуудын төлөөллөөс бүрдэх нь зохимжтой байж болно. Үүнд:



Уул уурхайн компаниуд, төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн төлөөллийг сонгосон, түүнд төлөөлөх эрх олгосон тухайгаа шийдвэр гаргаж баталгаажуулсан байна. Иргэд өөрсдийн төлөөллийг хангахын тулд иргэний нийгмийн байгууллагатайгаа хамтрах, хэрэв тийм байгууллага байхгүй бол иргэд дундаасаа тодорхой тооны хүмүүсийг сонгож Зөвлөлд оруулж болох юм. Төлөөллөө сонгохын тулд иргэд тусдаа хуралдаан хийж ч бас болно. Энд нэгэнт сонгогдсон төлөөллийн эрхийг бусад иргэд хүлээн зөвшөөрөх ойлголт их чухал байдаг. Учир нь эдгээр төлөөлөл нь цаашид бусад 2 талтайгаа эрх зүйн харилцаанд орж, байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтын талаар гэрээ, хэлцлүүдийг байгуулахад оролцоно. Нэгэнт гэрээ хэлцэл байгуулагдах явцад иргэдийн зарим хэсгээс өөрсдийн сонгосон төлөөллийг эсэргүүцэх нь оролцоог мухардалд оруулдаг муу талтай.

Олон тал зөвлөлийг үүсгэн байгуулах

Олон талт зөвлөл үүсгэн байгуулах үе шатууд дараах хэлбэртэй байж болох юм.



Сум орон нутаг өөрийн онцлогт тохируулан хамтын ажиллагааны бүтцээ ямар ч хэлбэрээр бий болгож болно. Өмнөх хэсэгт дурдсан Зөвлөлийн хэлбэр бол орон нутагт хийсэн хэлэлцүүлгийн үеэр талуудаас санал болгосон хувилбар юм. Ийм гурван талт бүтцийг дэмжсэн санаачилгууд сум орон нутгийн түвшинд төдийгүй үндэсний түвшинд бий болж байгаа нь сайшаалтай. Тухайлбал 2011 оны 3-р сарын 22-ны өдөр “Хариуцлагатай уул уурхайг Монгол улсад хөгжүүлэх” талаар Засгийн Газар, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо болон Иргэний нийгмийн байгууллагын хооронд Хамтын ажиллагааны гурван талт гэрээг байгуулсан. Өмнөговь аймгийн Цогт-Цэций суманд иргэдийн төлөөлөөс бүрдсэн Нутгийн зөвлөл байгуулагдаж, сумын захиргаа, “Энержи ресурс” компанитай хамтран орон нутагтаа хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санал санаачилгуудыг өрнүүлж байна. Өөр хэлбэрээр ч сайн ажиллаж буй газрууд бий. Тухайлбал, нутгийн удирдлага болон уул уурхайн компани хамтран хариуцлагатай ашиглалтыг хэрэгжүүлж байна. Оролцогч талууд хамтын ажиллагааныхаа бүтцийг бий болгохдоо Зөвлөл байгуулах үе шат, түүний зорилго, зарчмууд, чиг үүргүүдээс санаа авах хэрэгтэй.

Шигтгээ: Олон талт зөвлөлийг байгуулах зөвлөмж

1. Олон талт зөвлөлд иргэдийн төлөөллийг сонгохдоо Багийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн шийдэх. Ингэснээр ТББ-ын, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, эмэгтэйчүүдийн гэх мэт бүх төлөөлөл орох бололцоотой болно.
2. Багийн нийтийн хурлаас гарсан шийдвэрийг сумын ИТХ-д хүргүүлнэ.
3. Уул уурхайн компани Олон талт зөвлөлд оруулах өөрийн төлөөллийн нэрсийг сумын ИТХ-д хүргүүлнэ.
4. Сумын ЗДТГ-аас орох төлөөллийн нэрсийг Засаг дарга ИТХ-д хүргүүлэх.
5. ОТЗ-ийн нийт гишүүдийг сумын ИТХ-аар хэлэлцэн баталж тогтоол гаргана.
6. ОТЗ-ийн гишүүд тухайн жилд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө болон төсвийн төслийг гарган ИТХ-д оруулж батлуулна.
7. ОТЗ нь сумын ЗД-тай гэрээ байгуулж ИТХ-аар батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн хүрээнд ажлаа явуулна.
8. ОТЗ-ийн гишүүд нь орон тооны бус байх бөгөөд орон тооны зохицуулагчтай байна. Зохицуулагч нь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга байвал зохимжтой.
9. Зохицуулагч нь зөвлөлийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах, зөвлөлийг хуралдуулах, гарсан шийдвэрийг нэгтгэн ИТХ-ын даргад танилцуулан баталгаажуулах гэх мэт зохицуулалтын ажил хийнэ.
10. ОТЗ-өөс гарсан аливаа шийдвэрт сумын ИТХ-ын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
11. ОТЗ-ийн төсвийн гүйцэтгэлд сумын ЗД хяналт тавьж ажиллана.
12. ОТЗ нь гишүүдээрээ хэлэлцүүлэн баталсан өөрийн дотоод журамтай байна. Дотоод журамд ОТЗ-ийн хуралдах хугацаа, ирц, санал хураах, гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, гишүүдийг эргүүлэн татах, нөхөн сонгох асуудлыг заавал оруулна.

Жич: Энэхүү зөвлөмж нь заавал дагаж мөрдөх хууль, дүрэм биш бөгөөд орон нутгийн түршлага дээр үндэслэн гарын авлага зохиогчийн зүгээс санал болгож буй нэг хувилбар юм.



БҮЛЭГ 4

ОЛОН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон талт зөвлөл байгуулагдснаар талуудын оролцоог баталгаажуулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг төлөвшүүлэх урьдчилсан боломж бүрддэг. Олон талт зөвлөлийн ач холбогдол нь:

- Оролцогч гурван талын итгэлцэл, хамтын ажиллагааны суурь тавигдана.
- Орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах;
- Зөрчил маргаан гарахаас урьдчилан сэргийлэх;
- Уул уурхайн салбрын ил тод нээлттэй байх зарчим амьдралд хэрэгжих;
- Уул уурхайн компани урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах зэргээр олон талт хамтын ажиллагааны гэрээ амжилттай хэрэгжинэ.

4.1. ОЛОН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТУУД

Тухайн орон нутагт байгуулагдсан олон талт зөвлөл нь өөрийн үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд иргэдийн оролцоотойгоор олон талт хамтын ажиллагааны гэрээ байгуулахад эхний үйл ажиллагааг чиглүүлнэ. Энэ гэрээгээр байгаль орчныг хамгаалах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, ядуурлыг бүүруулах, хүний эрхийг дээдлэх, уул уурхайн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлага, хяналтыг тодорхойлж, албан ёсны баримт бичиг болгох боломжтой болно.

Олон талт зөвлөлийн үйл ажиллагааны үе шатууд:



4.2. ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтын талаар хамтын ажиллагааны гэрээ хэлцлүүдийг байгуулах нь Зөвлөлийн ажлын үндсэн үр дүн, оролцоо хэрэгжиж байгааг харуулсан баталгаа юм. Хамтын ажиллагааны гэрээ нь тухайн сум орон нутагт байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтыг бий болгох, тухайн сум орон нутагт талуудын хэлэлцэж тохирсон ажлуудыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Гурван талт гэрээг тухайн сумын нутаг дэвсгэр дээр байгалийн нөөц ашиглаж байгаа компани тус бүртэй байгуулах нь зүйтэй. Түүнчлэн тухайн сумын хэрэгцээнээс үүдэн тогтвортой хөгжилд чиглэсэн томоохон хөрөнгө оруулалт шаардсан төслүүд дээр хэд хэдэн компаниудыг оролцуулсан олон талт гэрээ хэлцлүүд байгуулж болно.

Хамтын ажиллагааны гэрээгээр талууд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээж, гэрээ зөрчигдсөн тохиолдолд тодорхой хуулийн хариуцлагыг хүлээхийг заасан байдаг. Энэ нь гэрээний эрх зүйгээр зохицуулагдсан, талуудаас хууль эрх зүйн мэдлэгийг шаардаж байдаг чухал ойлголт юм. Олон талт хамтын ажиллагааны гэрээ буюу иргэдийн оролцоотой гэрээ байгуулах нь уул уурхайн компани, засаг захиргааны байгууллагын нийгмийн хариуцлага, хуулийн хэрэгжилтэд олон нийтийн албан ёсны хяналт оролцоо бий болгох, хувийн хэвшлийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг дэмжих, сайн засаглалыг хөгжүүлэх, уул уурхайн үйлдвэрлэлээс үүдэлтэй байгаль орчин, хүний эрхийн зөрчлийг бууруулах зорилготой.

4.2.1. Гэрээний төсөл боловсруулах

Олон талт зөвлөл нь гэрээний төсөл боловсруулахтай холбоотой ажлын төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хурлаараа батлах хэрэгтэй. Ажлын төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүрийг хариуцах эзэн, оролцогчид, хугацаа, шалгуур үзүүлэлт, төсөвтэй нь оруулах шаардлага тавигдана. Дараах хүснэгтийг ашиглан төлөвлөгөөг хийж болно.

Жишээлбэл:

	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Оролцогчид	Шалгуур үзүүлэлт	Төсөв	Тайлбар
1.	Талуудаас гэрээнд тусгах саналыг авах						
2.	Саналуудыг нэгтгэх, зөвшилцөх						
3.	Гэрээний эхний хувилбар боловсруулах						
4.	Гэрээний төслийг талуудаар хэлэлцүүлэх						
5.	Олон нийт, иргэдээр хэлэлцүүлэх, зөвшилцөх						
6.	Хэлэлцүүлгийн дүнг нэгтгэн боловсруулалт хийх						
7.	Гэрээг байгуулах						
8.	Сумын бүх багийн ИНХ-д танилцуулах						

Гэрээний төслийн эхний хувилбар буюу тусгах асуудлын тоймыг гаргах нь тийм хүнд, хугацаа алдах асуудал биш. Нутгийн захиргааны зүгээс гэрээнд тусгах асуудлыг санал болгохдоо голдуу мөрийн хөтөлбөртөө тулгуурладаг бол иргэд өөрт тулгамдсан хувийн асуудлуудаа шийдвэрлүүлэхийг хичээдэг. Харин компани уурхай ажиллах хугацаанд гарч болох асуудлуудыг түлхүү авч үздэг байна. Гэрээнд юу тусгахыг эхний хувилбараар боловсруулсны дараа асуудал, заалт тус бүрээр нарийвчлан хэлэлцэх, иргэдийн саналыг авч сайжруулах гэх мэт шат дараалсан арга хэмжээнүүдийг авна.

Гэрээний төслийг боловсруулахдаа анхаарах нэг чухал асуудал бол гэрээний хэрэгжилтийн талаар иргэд хэрхэн мэдээлэл авах, хяналт тавих, санал гомдлоо хүргүүлж байх механизмыг тусгасан байх шаардлагатай.

Олон талт зөвлөлийн гишүүд болох нутгийн засаг захиргаа, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-ний тайлантай сайтар танилцах хэрэгтэй. Нарийвчилсан үнэлгээнд “Байгаль орчныг хамгаалах цогц төлөвлөгөө”, “Техникийн болон биологийн нөхөн сэргээлийн төлөвлөгөө”-г тусгаж эрх бүхий байгууллагаар батлуулсан байдаг гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Эдгээр төлөвлөгөөтэй танилцсаны үндсэн дээр гэрээнд байгаль орчныг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ямар үүрэг хүлээх, түүний хэрэгжилтэд хяналт тавих тухай асуудлыг хэрхэн яаж оруулж өгөх талаар мэдлэг ойлголттой болно гэсэн үг.

4.2.2. Гэрээний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх

Олон нийтэд мэдээлэл өгч, тэдний санал бодлыг сонсохоос гадна санал бодлыг нь гэрээнд тусгах ажил хамгийн чухал юм.

Олон талт зөвлөл нь гэрээний төслийг уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөлөлд өртөж болзошгүй бүсэд амьдардаг болон бусад иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад албан ёсоор танилцуулах нээлттэй уулзалтуудыг зохион байгуулна.

Тэдгээрийг татан оролцуулах үйл явцын хамгийн хүнд үе шатны нэг нь санал болгож байгаа гэрээний төслийн талаар янз бүрийн бүлгийнхэн санал бодол зөрчилдөөнтэй, эрс тэс байр суурь баримтлан санал нийлэхгүй байх үе. Энэ бүхнийг гэтлэн давахын тулд доорх аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

- Олон талт зөвлөлийн дэргэд дэд зөвлөлүүдийг байгуулах;
- Гэрээний төсөл боловсруулах ажлын хэсэгт өөр байр суурь баримталж буй бүлгээс төлөөлөл оруулах;
- Дугуй ширээний ярилцлага зохиох;
- Иргэдтэй ганцаарчилсан ярилцлага хийх;
- Олон нийтээс санал асуулга авах.

Тэднийг татан оролцуулснаар гэрээ байгуулагдсны дараа амжилттай хэрэгжих үрждчилсан нөхцөл бүрдэнэ. Гэрээний агуулга хичнээн баялаг байсан ч нутгийн иргэдийн саналыг тусгаагүй бол гэрээ амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгч чадахгүй.

4.2.3. Талуудын хооронд хэлэлцээр зохион байгуулах

Олон талт зөвлөлөөс боловсруулсан төсөлд холбогдох талуудын саналыг тусган эцсийн хувилбар дээр тохиролцоонд хүрэх нь энэ үе шатны гол зорилго. Өөрөөр хэлбэл, гэрээнд тусгах нөхцлүүдийг харилцан тохиролцох үйл ажиллагаа гэж болно. Тохиролцоонд хүрэх нь нэг удаагийн үүлзалт хэлэлцүүлгээр хийгдэх тийм амар хялбар ажил биш. Гэрээний төсөлд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхай ашиглах дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлуудаас гадна нутгийн онцлог, талуудын хэрэгцээнд тулгуурлан нэмэлт нөхцлүүдийг оруулах нь хамгийн чухал хэсэг нь байх болно.

4.2.4. Гэрээ байгуулах

Тухайн сумын нутаг дэвсгэр дээрх ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртэй олон талт хамтын ажиллагааны гэрээ байгуулагдана. Учир нь тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн ашиглах байгалийн баялаг өөр, хэрэглэх техник, технологи, олборлон борлуулах хүчин чадал, бий болгох ажлын байр, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ч мөн ялгаатай. Ийм учраас тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртэй харилцан адилгүй нөхцөл бүхий гэрээ байгуулагдана. Олон талт зөвлөл гэрээний сүүлчийн хувилбарыг боловсруулсны дараа талууд гарын үсэг зурж, ИТХ-аар баталгаажуулна. Ингэснээр олон талт хамтын ажиллагааны гэрээ хүчин төгөлдөр болж үйлчилж эхлэнэ.

Олон талт хамтын ажиллагааны гэрээг сумын нийт иргэдэд маш хүртээмжтэй байдлаар мэдээлэх шаардлагатай. Олон талт зөвлөлийн зүгээс гэрээг олон нийтэд танилцуулахдаа дараах арга хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын байран дах мэдээллийн самбаруудаар мэдээлэх;
- Олон талт хамтын ажиллагааны гэрээг иргэдэд танилцуулах уулзалт, нээлттэй өдөрлөг зохион байгуулах;
- Багийн ИНХ, Багийн Засаг дарга нараар дамжуулан өрх бүрт мэдээлэл хүргэх;
- Аймаг, сумын радио телевиз, сонин хэвлэл, компаний мэдээллийн хуудсаар дамжуулан сурталчлах гэх мэт.

Дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлснээр Олон талт зөвлөлийн ажлын эхний үе шат дуусна.

4.3. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ



Гэрээний хэрэгжилтийг зохих ёсоор хангах нь амаргүй асуудал. Тиймээс гэрээний хэрэгжилтэд бүх талууд хяналт тавих талаар эн тэнцүү эрхийг эдлэх ёстой. Түршлагаас харахад гэрээ зохих түвшинд хэрэгжихгүй тохиолдолд түүнд хариуцлага тооцох, шаардах асуудал үндсэндээ орхигдсон, олон нийтэд гэрээний хувь байдаггүй учраас хэрэгжилтийг шаардах боломжгүй болдог. Иймээс гэрээний хэрэгжилтийг хянах хамгийн сайн шийдэл нь Олон талт зөвлөл юм. Олон талт зөвлөл нь гэрээний хэрэгжилтийг тодорхой хугацаанд сумын нийт иргэдэд тайлагнах үүргийг хүлээнэ.

Уул уурхайн төслүүд хэрэгжиж буй газар нутагт байгаль орчин, нийгэм эдийн засаг болон хүний эрүүл мэндэд шууд болон шууд бус сөрөг нөлөөллүүдийг урт хугацаанд үүсгэн бий болгодог. Тиймээс сөрөг нөлөөллийг бууруулах талаар компаний төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих хэрэгтэй. Олон талт зөвлөл нь гэрээний хэрэгжилтийг үнэлэх боломжит шалгуур үзүүлэлт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулж тухайн сумын ИТХ-аар батлуулж хэрэгжүүлнэ.

4.3.1. Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих Олон талт зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх

Олон талт зөвлөлийн эрх, үүрэг, хариуцлагыг хамтын ажиллагааны гэрээнд маш тодорхой тусгаж өгөх нь чухал. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон талуудын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавихын тулд Олон талт зөвлөл үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Төлөвлөгөө нь орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн, хэрэгжихүйц, хэмжиж болохуйц, тодорхой цаг хугацаатай, хариуцах эзэнтэй байх хэрэгтэй.



Үйл ажиллагааны төлөвлөгөөний жишээ:

Батлав: сумын ИТХ-ын дарга

“.....” сумын Олон талт зөвлөлийноны үйл ажиллагааны төлөвлөгөө

	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Арга зүй
Нэг. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүргийн хэрэгжилт					
1.1	<p>Гадаргын болон гүний усны хяналт:</p> <ul style="list-style-type: none"> ● Уст цэгийн байршил ● Усны хэрэглээ ● Усны түвшин, чанар, нөөц ● Үйлдвэрлэлийн бохир усны хаягдлын менежмент 	Улирал тутам	ОТЗ	<ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрөлтэй талбайн ойролцоо байх гол, горхи, булаг шанд, нуур цөөрөм, үндны усны эх үүсвэрийн хэвийн байдал хангагдсан - Үйлдвэрлэлийн усны зохистой хэрэглээ болон дахин цэвэржүүлж ашигладаг - Гадаргын болон газрын доорх усны чанарыг тусгай хөтөлбөрийн дагуу байнга хяналт тавьдаг 	<p>Усны тооллого явуулах,</p> <p>Дээж авч шинжилгээ хийлгэх,</p> <p>Нутгийн иргэдэд түшиглэсэн ажиглалтын үнэлгээ хийх</p>
1.2	<p>Агаарын бохирдлын хяналт</p> <ul style="list-style-type: none"> ● Агаарын чанарыг тогтоох 	Хагас жилд	ОТЗ	<ul style="list-style-type: none"> - Тухайн бүс нутгийн агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг тогтоосон, эрэмбэлсэн - Нөлөөлөлд өртөх бүсийг тогтоосон 	Дээж авч шинжилгээ хийлгэх

1.3	<p>Хөрсний хяналт:</p> <ul style="list-style-type: none"> Хөрсний эвдрэл, элэгдэл, бохирдол Хатуу, шингэн, аюултай хог хаягдал 	Хагас жилд	ОТЗ	<ul style="list-style-type: none"> Хөрсөнд учруулсан хохирол болон эвдрэлд орсон газар нутгийн хэмжээ тодорхойлогдсон Орчныг хордуулах, бохирдуулах аливаа бодис, шатах тослох материалыг ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох төлөвлөгөөний хэрэгжилт 	Хэмжилт тооллого хийх, Дээж авч шинжилгээ хийлгэх
1.4	<p>Ургамал:</p> <ul style="list-style-type: none"> Ургамлын нөмрөгт учруулах аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх Нэн ховор болон ховор ургамлын аймгийг хамгаалах, ургамалжуулах 	Жилдээ	ОТЗ	<ul style="list-style-type: none"> Ургамлын нөмрөгт учруулсан хохирлын хэмжээ тодорхойлогдсон Нэн ховор болон ховор ургамлыг тарималжуулах ногоон байгууламж байгуулсан 	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
1.5	<p>Зэрлэг ан амьтан:</p> <ul style="list-style-type: none"> Нэн ховор болон ховор зэрлэг ан амьтныг хамгаалах 	Хагас жилд	ОТЗ	<ul style="list-style-type: none"> Хөрсөнд учруулсан хохирол болон эвдрэлд орсон газар нутгийн хэмжээ тодорхойлогдсон 	Нутгийн иргэдийн оролцоотой ажиглалт, тооллого явуулах
1.6	Техникийн болон биологийн нөхөн сэргээлт	Жилдээ	ОТЗ	<ul style="list-style-type: none"> Орчныг хордуулах, бохирдуулах аливаа бодис, шатах тослох материалыг ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох төлөвлөгөөний хэрэгжилт 	<ul style="list-style-type: none"> Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах Тоон болон чанарын үнэлгээ хийх

Хоёр. Орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих үүргийн хэрэгжилт					
2.1	Сумын дэд бүтцийг хөгжүүлэх	Жилдээ	ОТЗ сургууль, эмнэлгийн барилгыг засварлах	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
2.2	Жижиг дунд бизнесийг дэмжих	Улирал	ОТЗ	Сумын иргэд, аж ахуйн нэгжээс ... доошгүй бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг худалдан авсан.	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
2.3	Ажлын байрыг нэмэгдүүлэх	Жилдээ	ОТЗ	"..."ХХК-ий нийт ажиллагчдын ...хувь нь орон нутгийн иргэд байна.	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
2.4	Нөлөөллийн бүсийн иргэд, малчдын орлогын тогтвортой байдал	Жилдээ	ОТЗ	...иргэд, малчдын өвөлжөө, хаваржаа, орон байрыг нүүлгэн шилжүүлэх зардал, нөхөн олговор бүрэн олгогдсон.	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
2.5	Сумын хөгжлийн санд дэмжлэг үзүүлэх	Жилдээ	ОТЗ	Ашигт малтмал олборлон борлуулсны орлогын... хувьтай тэнцэх хөрөнгийг улирал бүр санд байршуулсан.	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
Гурав. Нийгмийн хөгжлийг дэмжих үүргийн хэрэгжилт					
3.1	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах	Харас жилд	ОТЗ	Нөлөөллийн бүсийн иргэд, малчдыг жилд ...удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байх.	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
3.2	Боловсролыг дэмжих	Жилдээ	ОТЗ	Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдийн анги танхимыг тохижуулах, ...доошгүй оюутанд сургалтын тэтгэлэг олгох	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах

3.3	Эмзэг бүлгийн хүмүүст суралцах боломж олгох	Жилдээ	ОТЗ	... доошгүй эмзэг бүлгийн иргэдэд өөртөө ажлын байр бий болгох, мэргэшүүлэх сургалтанд хамруулах	Төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах
3.4	Байгалийн түүх, дурсгалт газар, соёлын өвийг хадгалах, хамгаалах	Жилдээ	ОТЗ	Тусгай зөвшөөрлийн талбайд орших эртний булш, бунхан, түүх соёлын дурсгалт зүйл болон иргэдийн тахин шүтдэг газрыг хамгаалах, хөндөхгүй байх	Тооллого, баримтжуулалт

Жич: Олон талт зөвлөлөөс гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэхтэй холбоотой зардлыг маш сайн тооцох хэрэгтэй. Магадгүй шаардлагатай үед хуульч, байгаль орчны мэргэжилтэн хөлслөн ажиллуулах, хөрс, ус, агаараас дээж авч шинжлүүлэх гэх мэт зардлыг тооцох. Мөн Олон талт зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны зардал, урамшуулал ч багтана. Дээрх зардлуудаас орон нутаг дотоод нөөц бололцоогоороо хариуцан гаргаж болох зардлуудыг тодорхойлж, үлдсэнийг нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцах эсвэл түүнээс орон нутагт өгч буй хандив, тусламжийн тодорхой хэсгийг зарцуулах гэх мэтээр шийдвэрлэж болох юм.

4.4. ГЭРЭЭГ ТАЛУУД ХАМТРАН ДҮГНЭХ

Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан Олон талт зөвлөл нь хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тайланг жил бүр талуудын хамтарсан хуралд танилцуулж байна. Энэ нь олон талт хамтын ажиллагааны гэрээг дүгнэх суурь үзүүлэлт болно.

Олон талт хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан нийт зүйл, заалт бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэлт гаргана. Хэрэв тухайн жилд талуудын саналаар нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохирсон бол түүний биелэлтийг нэгэн адил үнэлнэ.

Олон талт зөвлөл нь сумын ИТХ-д олон талт хамтын ажиллагааны гэрээний биелэлтийг танилцуулна. Сумын ИТХ-аас гэрээний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгнө.

Зөвлөмж:

Гэрээ нь хугацааны хувьд аль болох удаан хугацаагаар буюу тухайн уул уурхайн үйлдвэрлэл эхлэхээс дуусах хүртэлх бүх үе шатыг хамран хийх нь оновчтой байж болох юм. Өөрөөр хэлбэл, уурхайн бүх үе шатыг хамруулан урт хугацааны ерөнхий гэрээ байгуулж хэрэгжилтийг жил тутам дүгнээд явж болно.

Ишлэл авсан хэвлэлийн жагсаалтууд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний III илтгэлийн хураангуй. УБ, 2009
- Шинжлэх ухааны академи. Монголын байгаль орчны нэвтэрхий толь. УБ, 2010
- Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр. УБ, 1999
- МХСМТ, Швейцарын хөгжлийн агентлаг, Байгалийн нөөцийн ашиглалт тогтвортой амьжиргаа. УБ, 2010.
- Азийн сан, Олон нийтийн оролцоо. УБ, 2008
- Нээлттэй нийгмийн форум, Хил хязгааргүй алхам ТББ. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга. УБ, 2008
- Хүний эрхийн хөгжлийн төв. Та эрхээ хамгаалж чадах уу. УБ, 2010
- Монгол улсын хүний хөгжлийн илтгэл-2011. “Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: байгаль орчин, хүний хөгжил” Улаанбаатар хот, 2011
- АНУ-ын Азийн сан. Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтанд талуудын оролцоог хангах нь. УБ, 2013
- АНУ-ын Азийн сан. Усны бодлого. УБ, 2011 АНУ-ын Азийн сан. Олборлох салбарт олон талт хамтын ажиллагааны гэрээ байгуулах. УБ, 2012

Хэвлэлийн эхийг “Вайслайт ХХК”-д бэлтгэв.